


ГЕРМАН МЕЛВИЛЛ



МОБИ ДИК

**Х.Мелвилл**

**Моби Дик**

## Аварга цагаан халимын ангуучдад юу тохиолдох бол?

Энэхүү зохиолын бичсэн Херман Мелвилл нь 1819 онд Нью-Йорк хотод худалдаачны гэрт төржээ. Гэвч аав нь долоон хүүхдээ үлдээн эрт нас барснаар тэдний гэр бүлийн аж амьжиргаа ихэд хэцүүдэн, гачигдаж дутагдаж эхэлсэн байна. Х. Мелвилл дунд сургуульд орсон ч хүнд амьдралын эрхээр хэдхэн сарын дараа сургуулиа орхин ажил хийж эхэлжээ. Хэдий ажил хийж байсан ч тэр маш их уншиж, өөрийгөө боловсруулж чадсан ба Их дээд сургуульд элсэнэ гэдэг нь түүнд алс холын мөрөөдөл төдий байсан гэдэг.

Фермер, худалдаачин, багш зэрэг маш олон төрлийн ажил хийн амьдралаа залгуулж байсан ч тэдгээр олон ажлуудын нэг нь ч түүний сэтгэлийг татаж чадсангүй. Тэр зөвхөн задгай их далайд л тэмүүлэн дурлаж байв. Тэгээд анх 18 настайдаа Английн Ливерпүүлээс ирсэн усан онгоцонд сууснаар түүний далайн олон адал явдал нь эхэлжээ. Тэр харгис хэрцгий ахмадын дарангуйлалд боолчлогдож, хүний махан идэштэнгүүдэд ч олзогдон, золоор Авсралийн халим ангуурын хөлгийн тусламжаар амь хэлтэрч, Номхон далайг хөндлөн гулд туулжээ. Далайн аяллаасаа буцаж ирээд Америкийн усан цэрэгт алба хаав.

Х. Мелвилл 1840 оноос эхлэн далайн ер бусын адал явдлуудынхаа тухай зохиол бичиж эхэлсэн бөгөөд 1891 онд нас барах хүртлээ маш олон зохиол бүтээл туурвижээ.

Тэдгээрийн дотроос “Моби Дик буюу цагаан халим” зохиол нь нэн алдартай. Олон тооны уянгын адал явдал, библи судрын ишлэл, зөн бэлгийн олон давхар ёгт утгыг агуулсан энэхүү зохиолыг тухайн цаг үеийнхэн ер ойлгож хүлээж авсангүй. 1851 онд хэвлэгдэн олны хүртээл болсон энэ зохиол 1920-иод оны үеэс дахин мэндэлжээ. Зохиолч энэхүү зохиолоо өөрийн дотны анд романтик зохиолч Натаниэль Хоторнд зориулж, “Аугаа их суу билгийнх нь өмнө илэрхийлэх хүндэтгэл” болгож бичсэн байдаг.

Америк далайчин Измаил “Пеход” хөлөгт дайгдан далайн аялалд гарч байгаагаар зохиол эхэлнэ. Энэ хөлгийн ахмад Ахаб нэгэнтээ түүнд хөлөө өргөл болгон өгсөн, халим ангуучдын эрлэг цагаан халимд өшөө зангидаж, түүнийг алахаар улайран зүтгэж яваа аж.

Ахаб далайчиддаа байнга сонор сэрэмжтэй байж, цагаан халим харуулдахыг тушаах агаад Моби Дикийг хамгийн анх олж харсан хүнд алтан зоос өгөхөө амладаг.

Хөлөг онгоцон дээр учир нь үл тайлагдах адал явдал ар араасаа өрнөж, ахмад Ахаб өшөө хорслын улайралдаа эрүүл ухаанаа алдана. “Пеход” болон түүнээс буусан завиуд хэд хэдэн удаа Моби Дикийг гүйцэх шахаж, олз омог арвинтай явна. Эцэст нь Моби Дик “Пеход” хөлгийнхөнтэй эрэгчин эмэгчнээ үзэлцэн тулалдана.

Дээрээс илгээгдэж байгаа зөн ёрын хүчийг жирийн далайчид тэсэж гарах болов уу.

Та бүхэн энэхүү номыг уншсанаар он удаанаар аялсан далайчин эр мэт далайн аялал, халим ангуучлалын маш олон нарийн ширийн зүйлстэй танилцаад зогсохгүй хүний хүсэл зориг гэгч ямар агуу гайхамшигтай болохыг мэдэрч бахдах болно гэдэгт итгэлтэй байна.

**“Хөх дэвтэр” хэвлэлийн газар**



# Нэгдүгээр бүлэг

## Хачин хүнтэй нэг өрөөнд оров

Намайг Измайл гэдэг. Би уг нь багш хүн л дээ. Амьдралд маань ямар нэгэн бүтэлгүй зүйл тохиолдож, сэтгэл санаагаар унаж гэмээ нь би ажлаа орхин, ер бусын орныг зорин явахад бэлэн байжээ. Их далай хэзээ ямагт сэтгэл баясгаж, урам зоригийг сэргээдэг гэдэгт би итгэж, найддаг билээ.

Гэхдээ би жирийн л нэгэн зорчигч байх тухай яриагүй байна. Үгүй ээ, би төрөлх хот Нью-Йоркийн Манхэттанд очихын тулд жирийн нэг далайчин болоход л хангалттай. Би булчин шөрмөсөө чангалан дасгал хийж, бас бусдад мөнгө төлөхийн оронд бусдаас төлбөр авахыг илүүд үзнэ. Бас холын холд хүрч үзэхийн тулд байж ядан оргилох их хүслээ дагах дуртай.

Тиймээс ч энэ удаа жирийн нэг худалдаачны онгоцоор явахын оронд Массачуссэтийн далайн эрэг дэх халимын эх орон Нантукет арлаас халим агнуурын онгоцонд дайгдан явахаар шийдлээ. Эхлээд би Шинэ Бедфорд руу явж, дараа нь Нантукет хүртэл жижигхэн завиар явах хэрэгтэй байлаа.

Арван хоёрдугаар сарын нэгэн тасхийм хүйтэн шөнө, бямба гараг юм даг, би бага зэрэг азгүйтсээр Шинэ Бедфордод ирсэн юм. Сүүлийн завь Нантукет руу саяхан хөдөлсөн байх агаад даваа гарагийн өглөө хүртэл явах унаа байхгүй гэнэ. Би Шинэ Бедфордод хоёр шөнийг өнгөрүүлэх нэмэгдэл зардлыг тооцоолоогүй байсан хэдий ч надад өөр сонголт байсангүй. Ингээд би хямдхан буудал хайж эхэллээ.

Сэтгэл хөдөлгөсөн бодол санаа, хөгжилтэй дурсамжуудаа халаасандаа нандигнан, мөс шиг хүйтэн шуурганд урагшилсаар. Эцэст нь усан онгоцны зогсоолын ойролцоо байрлах навсайсан шовгор байшинд дөхөн ирэв. Ус цацран олгойдсон зургийнх нь доогуур “Петер Коффены Халимын ус оргилуулагч дэн буудал” гэсэн бичигтэй самбар тамтаг болсон хаалганых нь дээгүүр нааш цааш савлана.



“Тийм ч сонирхол татахаар эд биш юм, гэхдээ хаалганы гадна нүдчих жавартай шөнөөс арай л дээр” хэмээн дотроо бодов.

Хаалга руу зүглэхэд хамгийн анх харсан зүйл маань халим болон живж буй онгоцны үрчийж шарласан баргар зураг байсан юм. Өөр нэг хана нь бороохой шийдэм, жад, халим агнуурын жад болон зэвтэй гинжит сумнууд... ер нь бүхий л төрлийн аймшигт зэвсгүүдээр дүүрсэн байв. Сархад зооглох газрын хаалга нь догшин халим амаа ангайж буй мэт нуман хэлбэртэй агаад дотор нь үрчлээнд баригдсан үйлчлэгч өмнөх дарснудаа хольж хутган сууна.

Буудлын эзэн бүх өрөөнүүд нь дүүрсэн, хэрэв хүсвэл хэн нэгэн халимын ангуучтай хамт нэг ор хуваалцах боломжтой гэв. Надад тэр санал таалагдаагүй ч нэг өрөөг хамтран эзэмших нь иймэрхүү жижиг хотын дэн буудалд байдаг л нэгэн нийтлэг зүйл гэдгийг мэдэж байсан болохоор би буудлын эзэнд,

- Хэрэв надад өөр сонголт байхгүй бол олигтойхон шиг эртэй хөнжил хуваалцахыг тэсвэрлэнэ ээ хэмээлээ.

Оройн хоолны турш би өнөөх халим агнагчийн ирж яваа эсэхийг харуулдсан авч тэр хүн харагдсангүй. Би хачин жигтэй энэ хотод огт танихгүй тэр нэгэн бүдүүлэг халим агнагчтай нэг оронд унтахаас аягүйцэж байснаа нуух юун. Бараг шөнө дунд хүртэл хаалганы дэргэд зовнил дүүрэн харцтай суусан хэдий ч түүнээс ямар нэгэн ажиг сураггүй.

- Буудлын эзэн гуай, - хэмээн эцэст нь би босож түүн дээр очоод, - Тэр хаана байгаа юм бол? Ингэж их оройтдог юмуу? Тэр ер нь ямаршуу хүн бэ? гэлээ.

- Ерөнхийдөө бол тэр өт түүгээд явчихдаг эртэч шувуухай л гэсэн үг – хэмээн тэр тайлбарлав.  
- Гэхдээ тэр энэ орой наймаа хийхээр явсан. Нөгөө төвөг учруулаад байдаг толгойнуудаа зарах хэрэгтэй шүү дээ.

- Юугаа гэнэ ээ? хэмээн би хашгирах шахам хэллээ.

- Тайвшир даа, тайвшир. Тэр халимын ангууч саяхан Шинэ Зеландын өмнөд далайгаас их хэмжээний үрчийж хорчийсон, занданшуулсан толгойнууд авч ирсэн юм. Энэ их хачин зүйл гэдгийг чи мэдэж байна уу. Тэр нэг толгойгоо зарсан гэнэ лээ. Уг нь би түүнд маргааш хүмүүс нь бүгд сүм рүү очих учир энэ гудамжинд хүний толгой зарагдахгүй шүү гэж хэлсэн л юмсан.

- Тэр үнэхээр аюултай хүн шиг сонсогдож байх чинь.

- Гэхдээ л тэр хөлсөө тогтмол төлдөг юм. Намайг зовоож болох бүхий л золон гэвэл ердөө л энэ, одоо таныг өрөөнд чинь хүргэж өгье дөө гээд буудлын эзэн лаагаа асаав.

Хуучны далайн авдар болон дөрвийн дөрвөн халим агначдад ч хангалттай том орыг тэр бяцхан өрөөний голд байрлуулжээ. Тэнд түүнээс өөр тавилга гэхээр зүйл байсангүй. Өөр онцлох зүйлс гэвэл засаж янзлаагүй тавиур мөн тун хуучны нэгэн модон сандал л байна. Далайчны тээш нь шалан дээр, урт загасан сэрээ нь орны хажууханд байлаа.

Би буудлын эзнийг явсны дараа аажмаар тайвшран, лаагаа ширтсээр удалгүй гүн нойронд дарагдлаа.

Гэнэт, хонгилоор чанга чанга алхлах хөлийн чимээ намайг сэрээхэд, өрөө рүү минь нэгэн цагаан гэрэл ирж байгааг би харав.

“Эзэн минь намайг хамгаалаарай, энэ нөгөө толгойн наймаачин байхаас зайлахгүй” хэмээн би бодлоо.

Чив чимээгүй хэвтэх зуураа Шинэ Зеландын нөгөө аймшигтай толгойнуудаа аяллын цүнх рүүгээ чихэж буй түүний сүүдрийг ажиглаж байв. Тэрээр хүнд гээчийн далайн хүрмээ сандал дээр хаяад, тээшиндээ ойртон улаан арьстны хангинуур сүх шиг нэгэн зүйл авлаа. Би түүний нүүрийг огт харж чадахгүй байсан ба тэр бүхнийг харж байхдаа мөс шиг л хөшиж орхисноо мэдэрч байв.

Нүүр нь бараавтар ягаан өнгөтэй, түүн дээр том том дөрвөлжин хар зүйлс наалдсан мэт харагдана... Малгайгаа авахад нь би бүр гайхаж орхив. Түүний толгойд нь ямар ч үс байсангүй, зөвхөн оройныхоо хуйханд орооцолдсон юм шиг хэсэгхэн урт үс үлдээгээд үлдсэнийг нь хусжээ. Түүний хар ягаан өнгөтэй халзан толгой яг л хөгцөрсөн гавлан бөмбөрцөг шиг ажээ.

Тэрээр өөр ямар нэгэн хачин зүйл үзүүлэлгүй хаалганы наана тухлан суухад үхлийн айдаст автсан би өрөөнөөс үсрэн гараад хаашаа ч хамаагүй зайлж болох байлаа. Гэвч би түүний хэрхэн амарч буйг чимээгүй ажиглан, зүгээр л хэвтэж байсан хэрэг.

Түүний цээж, гар, нуруу нь яг л нүүр шигээ алаг эрээн бөгөөд хөлийг нь залуухан дал модны ишин дээгүүр өгсөх хар ногоон мэлхийн шивээс битүү бүрхжээ.



Тэр өнөөх хүрмээ чулууддаг сандал руугаа дөхөж очоод халааснаасаа цөөхөн хэдхэн модны зомгол, усан онгоцон дээр өгдөг жигнэмгийн хэлтэрхий, лаа, онгон шүтээн нь бололтой, бяцхан бөгтөр хүний дүрс зэргийг гаргаж ирснээ тэдгээрийг задгай зуухны дээд талын тавцан дээр байрлуулав.

Дараа нь тэр нэгэн төрлийн өргөл барьж байгаа аятай лаа асаан, жигнэмгээ шатааж эхэлсэн нь өнөө жаахан бөгтөр дүрс бүхий шүтээндээ тахил өргөж байх шиг.

Нүүр царай нь энгийн биш, татвалзаад ч байгаа юм шиг болж, бас хоолойноосоо их сонин дуу авиа гаргана. Түүний энэ баяр ёслолын байдалтай мөргөлийн зан үйлийг би зөвхөн гайхан харахаас өөр юу ч хийж чадсангүй.



## Хоёрдугаар бүлэг

### Насан туршийн минь анд

Эцэст нь тэр нөгөө бяцхан галаа унтрааж, шүтээнээ хүрэмнийхээ халаасанд буцаан хийлээ. Би түүнтэй зориг гарган ярилцахыг оролдсон ч гэнэт тэр улаан арьстнуудын хангинуур сүх шиг нэг зүйлийг шүднийхээ завсар зуугаад, түүн рүүгээ асаалттай шүдэнз аваачиж, их ихээр утаа гарган тамхилж эхлэв. Тэгснийхээ дараа ор руугаа үсрэн орлоо.

Би арайхийж нэг дуугарахад тэр ч мөн гайхсандаа болж, хачин авиа гаргав. Би үг хэлэх гэсэн боловч чадсангүй, ээрэн гацаж, хана руу өнхөрлөө.

Түүнийг өнөөх сүхэн гаансаа сэгсрэн, халуун үнсээ эргэн тойронд тараан орилж эхлэхэд нь намайг тэр зэрлэг сүхээрээ цавчих вий, мөн орыг минь галдан шатаачих вий гэдгээс үхтлээ айлаа.

Гэнэтхэн,

- Хэн гэгч чөтгөр вэ? Дуугараач, эсвэл там руу чинь тонилгочихно шүү... гэх нь тэр.

Би бушуухан шиг л,

- Тэнгэрийн авралаар гэрэл аваад ирээч дээ! хэмээн буудлын эзнийг дуудан хашгирлаа.

- Битгий ай! - гэсээр буудлын эзэн онгорхой хаалган дээр ирэв. - Кюкег чиний толгойн нэг ширхэг үсийг ч оролдохгүй.

- Та яагаад надад энэ халимын ангуучийг махчин гэж хэлээгүй юм бэ?

- Би чамайг мэдэж л байгаа юм бодсон шүү дээ. Чамд түүнийг толгойн наймаа хийж байгаа тухай хэлсэн шиг санагдана, - гэснээ Кюкег рүү эргэн хараад, - Түүнийг хар л даа, тэр унтаж л байгаа биз дээ? гэлээ.



- Би унтаж байна гэж үү? хэмээн Кюкег жуумалзаад өнөөх гаансаа ахин уугиулж эхлэв. Удсан ч үгүй тэр хөнжлөө хөдрөөд намайг орондоо орооч гэсэн мэт их л эелдэг дохилоо. Би түүний сайхан харцыг ажиглан, яагаад ч юм түүнийг дотор нь орсон юм шиг мэдэрч, тэр ухаалаг сайн залуу шиг санагдлаа. Магадгүй би түүнээс айсан шиг, тэрэнд мөн намайг айлгах шалтгаан ч байсан биз ээ.

- Тэгэлгүй яахав, эрхэм ээ. Гэхдээ түүнд сүхээ өөрөөсөө холдуул, мөн орондоо тамхи татахаа боль гээд хэлээд өгөөч, би галын даатгалд даатгуулаагүй яваа гэж би буудлын эзэнд хэллээ.

Кюкег энэ бүхнийг зөвшөөрсөн маягтай цаашлан хэвтээд,

- Та надаас айх хэрэггүй гэхэд нь би буудлын эзэнд хандан,

- Та явж болно оо, эрхэм ээ, сайхан амраарай! хэмээв.

Маргааш өглөө нь, Кюкег эртлэн босч хувцаслаад намайг өрөөндөө ганцаар үлдэх боломжтой болсныг илэрхийлэн эелдгээр дохио өглөө. Өрөө хамтран эзэмшигчдээ би л анх бүдүүлэг зан гаргаснаас биш тэр маань их эелдэг эр байжээ. Эхлээд урт минжин малгайгаа углан, дараа нь орон дороос гутлаа болгоомжтой татаж авахыг нь би нэг их удаан ажиглаж чадсангүй.

Энэ бүхний дараа тэр өмд болон цамцаа өмсөхөөр зугуухан хөдөллөө. Хувцаслаж гүйцээд тэрээр савангийн хэлтэрхий аван нүүрээ хөөсрүүлж эхлэв. Тэгээд удалгүй гаргаж ирсэн сахал авах багаж нь намайг багагүй гайхашруулж чадлаа. Өнөө улаан арьстных баймаар сүхнийхээ толгойг урт ишнээс нь салгаж аваад, гутлынхаа түрийн дээр ирлэж эхлэв.

Дараачийн мөчид тэр өнөөх ган зэвсгээрээ хоёр хацраа дадмаг гэгч нь шудрав. Би үүнийг яг

харж байх тэр агшиндаа л их гайхаж байсан ч хожим нь халим агнадаг жадны сайн чанарын ган толгой ямар хурц байдгийг мэдсэн хойноо тэр гайхашрал маань ердийн зүйл болж хувирсан билээ.

Өглөөний цайны үеэр, дадлага, туршлагыг насан туршдаа хуримтлуулсан халим ангуучдын сонирхолтой адал явдлын түүхийг сонсох таатай байна байх даа гэж бодсон авч надад тийм боломж гарсангүй. Учир нь тэд түүх ярихын оронд нэг л ичингүйрсэн янзтай, чимээгүй баавгай мэт сууцгаана. Тэдэн дунд халим ангуурын жадаа барин орж ирсэн Кюкег л хамгийн завгүй нь байв. Кофе болон халуунаараа байгаа жижиг талхнуудыг үл тоомсорлон, ширээ давуулан байж, шүүрхийдүү жигнэсэн үхрийн махнаас нэг нэгээр нь жадлан авсаар байлаа.

Хоолны дараа би түүнийг зааланд ганцаараа байхад нь олж очлоо. Ширээн дээрээс нэг том ном авснаа өөрийнхөө бололтой нэгэн үл мэдэгдэх хэлээр хуудсыг нь аажуухан тоолж буй харагдана. Яг тавин хуудас болсны дараа тэрээр зогсосхийж, нийт хичнээн хуудас байгааг нь гайхсан маягтай исгэрээд, дахиад л тоолж эхэллээ. Би түүнийг буурчийн газарт байгаа бусад далайчидтай яагаад дотносоогүйд нь дотроо гайхаж байсан авч бараг нэг хормын дотор л тэр надад таалагдаад явчихав. Үнэхээр энэ хүн чинь төрөлх нутаг - Шинэ Зеландаасаа 20000 бээрийн холд, бараг л Бархасбадь гараг дээр байгаа мэт хүн шүү дээ. Тэрээр хараахан өөрийг нь байгаа байдлаар нь ойлгох нөхрөө, мөн тийм сэтгэл ханамжтай нөхөрлөлөө олоогүй байгаа бололтой. Би түүн рүү дөхөх хэрэгтэйг мэдрэн, вандангаа ойртуулж, ярилцах гэтэл тэр надаас энэ шөнө ахин нэг өрөөнд орох эсэхийг асуув. Би “Тийм” гэсэн хариу хэлэхэд тэрээр над руу ямар нэгэн юм өөрчлөх гээгүй байгаад минь урамшсан шинжтэй талархан харлаа.

Би түүнд номон дээрх үсэг болон зураг ямар утгатай болох талаар тайлбарлахыг оролдож, мөн тамхилах санал тавихад тэр тамхиныхаа уут болон нөгөө сүхэн гаансаа гаргаж ирснээр бид хэдэн цагийн турш өнөөх гаансаа нааш цаашаа дамжуулж суулаа. Бидний тамхи ч дуусав.

Эцэст нь, шинэхэн найз минь намайг налнаа духаа духанд минь хүргээд, бүсэлхийгээр тэвэрлээ. Бид одоо түүний нутгийн хэллэгээр “гэрлэсэн” буюу сайн найзууд болсон, найз маань миний төлөө үхэх хэрэг гарвал үхэхэд ч бэлэн байна гэсэн юм. Америк хүмүүс бид бие биендээ тийм ч хурдан итгэдэггүй. Сайхан нөхөрлөл гэгч тэр зүйл нэн даруй бий болдоггүй билээ. Би тэрхүү цагаан цайлган, гэм хоргүй, зэрлэгдүү ч гэмээр энэ хүний сэтгэл хийгээд хуучны тэр ёс заншилд нь нэг их ач холбогдол өгсөнгүй.

Оройн хоолны дараа бид өрөөндөө орж, бас дахин нөхөрсгөөр тамхиллаа. Найз маань надад нөгөө занданшуулсан толгойноосоо нэгийг бэлэглэв. Мөн тамхины уутаа гаргаж ирснээ доогуур нь тэмтэрч тэмтэрч задгай гучин доллар гаргаж ирээд хоёр хэсэгт хуваан нэгийг нь намайг ав гэхэд нь би татгалзахыг оролдсон ч тэр халаас руу минь хийж орхилоо.

Дараа нь тэр урьд шөнийн ёслолд хэрэглэсэн өнөө бөгтөр дүрсээ гаргаж ирээд намайг түүндээ хамт байлцахыг урьж байгаа бололтой дохив. Тэр бүхэнд заасан ёсоор нь хүндэтгэл илэрхийлэхэд үнэндээ надад хүндрэлтэй байсан юм. Би зөвхөн Их Христ, өөрийнхөө шашинд л сүсэлж мэднэ, өөр зүйлд итгэвэл дүрэм зөрчиж байгаа хэрэг болно. Гэсэн хэдий ч дараа нь би тэрхүү бүх дэлхийг захирагч агуу Бурхан энэ бяцхан модны хэлтэрхийд атаархахгүй байх аа гэж бодов. Магадгүй түүний надаар хийлгэх гээд байгаа энэ зүйлд Бурхан талархалтай ч

хандах юм билүү.

Тиймээс би лаа асаан, тэр бөгтөр дүрсэнд түлэгдсэн жигнэмгээр өргөл өргөөд мөргөл үйлдэв. Мөргөлийнхөө дараа харин орондоо орсон билээ.

Бид хоёр маргааш өглөө нь эртлэн бослоо. Кюкег надад гарал үүслийнхээ талаар ярьж эхлэв. Кюкег бол Номхон далайн өмнөд хэсэгт орших Коковоко хэмээх нэгэн бяцхан аралд төржээ. Түүний аав хаан, авга ах нь тэр нутгийн санваартан аж. Насан өндөр аав нь хорвоогоос халихад Кюкег хаан болно. Гэвч тэрээр Христийн ертөнцтэй танилцан, өөрийнхөө ард түмэнд их хөгжил авчрахыг хүссэн ажээ.



Нэгэн удаа Коковоко арал дээр ирсэн халим агнуурын онгоцны ахмадаас өөрийг нь авч яваач гэж аминчлан гуйсан ч ахмад зөвшөөрөөгүй гэлээ. Гэсэн ч Кюкег бууж өгсөнгүй. Нарийхан гуя завиа сэлүүрдсээр боломжтой цагийг хүлээн, дагаж явсаар завь нь эвдэрч далайд живэх үед мань эр онгоцны тавцан дээр авиран гарч амжжээ. Ахмад дахиад л үгүй гэжээ. Гэвч тэр арлын эзний хүү бараг үхэх гэж байгааг хараад зөвшөөрчээ. Тэнд л Кюкег халим хэрхэн агнадгийг сурсан аж.

- Чи тэгээд хаан ширээгээ өвлөн авах бодолтой байгаа юу? гэж намайг асуухад,

- Кюкег далайчдын гаргадаг ааш авирыг хараад Христос нь хүртэл тийм ч ариун ёс суртахуунгүй юм байна гэж мэдсэн, - гэж тэр хэлэв. - Тэгэхээр одоо Кюкег дээд удмынхаа

өндөр ёс суртахуунтай гучин хааны нэр төрийг гутаах байх аа. Үгүй ядаж л Кюкег бие сэтгэлээ дахин ариусгах хүртэл шүү дээ.

- Тэгвэл одоохондоо чи юу хийх вэ? гэж намайг асуухад,

- Хөлөг онгоцоор дахин аялах болно оо гэж хатуу хэллээ.

Би Нантукет руу халим агнагчдын онгоцоор аялах гэж байгаагаа хэлэхэд Кюкег,

- Найз минь, би чамтай хамт тэр онгоцон дээр байх болно гэв.

Надад баярлах хоёр шалтгаан байлаа. Кюкег бол миний найз, мөн тэрээр маш туршлагатай халимын ангууч. Түүнчлэн, тэр анхны минь далайн аялалд сайн багш минь байх болно.

# Гуравдугаар бүлэг

## Ахмад Ахабын нууц

Маргааш өглөө нь өөрсдийнхөө ачаа тээшийг усан онгоцны зогсоол руу хүргүүлэхээр бид түрдэг тэрэг хөлслөн авлаа. Найз маань анх удаа түрдэг тэрэг хэмээх энэ зүйлийг хараад хэрхэн ашиглахаа мэдэхгүй байсан тухай надад ярив. Тэр далайчны авдраа тэргэн дээрээ тавиад, тэргээ нуруундаа үүрч явсан гэнэ.

- Тэгэхэд хүмүүс инээгээгүй юү? гэхэд минь тэр,

- Хүн болгон л өөр өөрийнхөөрөө инээж байсан байх, би чамд өөр нэг түүх ярья гэв.

Хөлөг онгоцны ахмад өмнө нь Коковоко арал рүү аялан очиж байжээ. Тэрээр Кюкегийн эгчийн хуримын ёслолд уригдсан юмсанж. Хамгийн ахмад санваартан наргил модны самрын жүүс цэлэлзсэн том аягатайг зочдод хүргэхээс өмнө түүнийг адислан, хуруугаа дүрчихэж л дээ. Ахмад гэтэл тийм ёстой юм байх гэж бодоод жүүсээр гараа угаасан...

- Чи юу гэж бодож байна даа? Кюкегийн хүмүүс инээлдсэн болов уу? гэж түүнийг инээмсэглэн хэлэхэд,

- Тийм ээ Кюкег, би тэднийг тэгсэн гэж таамаглаж байна гэж би хариулав.

Бид далайн эрэгт ирээд Мосс гэх нэг бяцхан онгоцны тавцан дээр гарлаа. Энэ онгоц Шинэ Бедфордоос Нантукет рүү явах байлаа. Зорчигчдын зарим нь Кюкегийг шоолж эхлэв, ялангуяа нэг зорчигч түүний уурыг ихэд хүргэв. Кюкег жадаа газар хаяад тэр бүдүүлэг эрийг агаарт өргөн шидлээ. Түүнийг унаж байхад нуруун дээр нь зөөлөн алгадахад тэр хүн яг хөл дээрээ буув. Кюкег нуруугаа түүн рүү харуулж, өнөө сүхэн гаансаа асаалаа.



Өнөө хүн ахмад дээр очин тайлбар хийв. Төд удалгүй ахмад гүйн ирэв.

- Чи наадахаараа юу хийх гээд байгаа юм бэ? Чи түүнийг алж ч магадгүй байлаа шүү дээ гэж хашгирав.

- Тэр юу гэсэн бэ? хэмээн Кюкег тайвнаар асуухад,

- Чи түүнийг бараг эд бад хийх дөхсөн байна гээд ахмад өнөө чичирч буй хүн рүү хуруугаараа заалаа. Кюкегийн царай зэвүүцэж буй мэт болоод,

- Түүнийг алах аа? Тэр чинь ердөө л жижигхэн загас шүү дээ. Кюкег жижиг загас алдаггүй, Кюкег том халим л агнадаг! гэлээ.

- Хэрэв чи дахиад ийм янзын тоглоом тохуу хийхийг оролдвол алчихна шүү, махчин минь. Болгоомжтой л байгаарай! хэмээн ахмад яг л араатан шиг архирав.

Гэхдээ энэ удаа ахмадын болгоомжтой байх цаг байжээ. Онгоцны далбааг өргөхөд хэрэг буруугаар эргээд явчихав. Далбааг дэлгэх зориулалттай урт тулгуур шураг гэнэтхэн савлаж, нэг савлалтаараа өнөөх бүдүүлэг эрийг онгоцон дээрээс авч шидээд үргэлжлүүлэн савласаар л, хугарч унахаас нааш зогсохгүй юм шиг санагдав.

Хүн бүр л яах учраа олохгүй, хөлдөж орхисон юм шиг тавцан дээр зогсоно. Харин Кюкег юу

хийхээ мэдэж байсан аж. Эхлээд тэр тас няс хийсэн шураг доогуур мөлхсөөр хуйлаатай олсон дээр очлоо. Нэг үзүүрийг нь тавцангийн хашлагаас уяд нөгөө үзүүрийг нь бугуйл шиг толгойн дээгүүрээ эргэлдүүлэн шидэж, толгой дээгүүрээ нисэж байсан шургийг цаламдан авч бэхлэв. Бүх зүйлс нам гүм боллоо.

Эцэст нь тэр цамцаа тайлаад хөөсөрч буй мөс шиг ус руу орж явчихлаа. Бид тэнд сэлж яваа Кюкегээс өөр юу ч олж харсангүй. Гэнэт Кюкег үзэгдэхээ больж, төд удалгүй усны мандал гарч ирэхдээ нэг гараараа сэлүүрдэж, нөгөө гараараа ухаангүй гулзайх хэн нэгний биеийг чирч явав.

Ийнхүү бүдүүлэг эр аврагдаж, ахмад Кюкегээс уучлал гуйв. Би ч бас сайн найзынхаа дэргэдээс хэзээ ч холдохгүй гэж шийдлээ. Гэсэн хэдий ч бид Мосс Нантукетэд хүрэхэд түр зуур салах хэрэгтэй болов.

Шинэ Бедфорд дахь өрөөндөө байхад түүний биеэсээ салгалгүй авч явдаг Ёожо нэрт бяцхан шүтээн нь Кюкегт нэг мэдээлэл дамжуулсан гэнэ. Тэр мэдээллийн дагуу би ганцаараа очиж халим агнуурын онгоцыг сонгох хэрэгтэй байсан юм.

Би гурван жилийн хугацаатай халимын ан хийхээр явах бүх онгоцнуудыг судалсны дараа Пекүд хэмээх хуучны загварын нэг жижигхэн онгоцыг сонголоо.

Тавцан дээр зогсох наранд борлож, үрчлээтсэн нүүртэй эрхэмтэй танилцаад тэдний багт орох сонирхолтой байгаагаа хэлэв. Тэр хүн өөрийгөө Пекүдийн бас нэгэн эзэмшигч ахмад Пелг хэмээн танилцуулав. Тэрээр,

- Чи яагаад заавал халим агнуурын онгоцыг сонгож байгаа юм бэ? Би чамайг хөлсөлж авахаасаа өмнө чухам яагаад ингэж байгааг чинь мэдмээр байна? гэхэд,

- Тэгэхээр, эрхэм ээ, юу л даа, би зүгээр л халим агнах ямар байдгийг харах гэж хүссэн юм гэж би хэлэв.

- Чи ахмад Ахабтай тааралдаж үзсэн үү?

- Ахмад Ахаб гэж хэн юм бэ, эрхэм ээ?

- Тэр бол энэ онгоцны ахмад, чи уг нь халимын анд гарахаасаа өмнө түүнийг нэг харчихсан бол зүгээр л байсан юм. Хэрэв өрөөсөн хөлтэй хүн тааралдвал тэр чинь ахмад Ахаб шүү.

- Тэр халимын анд явж байгаад хөлөө алдчихсан юм уу?

- Халим агнаж яваад хөлөө алдсан гэв үү? Залуу эр минь, тэр далайд байдаг хамгийн том мангаст хөлөө өгсөн юм даа.

Тэр хөгшин ахмадын түүх бодлыг минь өөрчилсөнгүй, эцэст нь би түүнд энэ ажилд орохоор хатуу шийдсэн гэдгээ итгүүлж чадлаа. Би түүнд Кюкегийн талаар ярихад тэр түүнийг авчир гэсэн юм. Би Пекүдийн тавцан дээрээс буун явахдаа онгоцны ахмадтай уулзаагүйгээ санан,





- Би ахмадыг хаанаас олж болох вэ? хэмээн түүнээс асуухад,
- Чи одоо түүнтэй уулзаж яах юм бэ? Нэгэнт багт орсноос хойш болоо юм биш үү гэв.
- Тийм л дээ. Гэхдээ л би түүнтэй уулзахсан гэж хүсэж байна.
- Тэгсэн ч гэсэн уулзахын тухайд найдвар тавихын хэрэггүй. Тэр өвчтэй байгаа... Үгүй ээ, тэр яг ч өвчтэй биш л дээ, тэр сайнгүй байгаа. Юутай ч тэр үргэлж бидэнтэй уулзаад байдаггүй, тиймээс би түүнийг чамтай уулзана гэж бодохгүй байна. Тэр жаахан хэцүү зантай. Гэхдээ тэр их сайн хүн... тийм ээ, сайн хүн шүү. Тэр бол Библид нэр нь дуурьсагдаж үлдсэн хааны нэртэй хүн гэдгийг чи мэдэх үү.
- Тийм л дээ, гэхдээ тэр Библид гардаг Ахаб хаан чинь хорон санаанаасаа болж алуулсан биз дээ?
- Пекүдийн тавцан дээр байхдаа хэзээ ч битгий тэгж хэл. Ахаб өөрийнхөө нэрийг сонгоогүй шүү дээ. Би ахмад Ахабыг сайн мэднэ. Магадгүй тэр гэр лүүгээ явж байгаа сүүлчийн аялалдаа сэтгэл санаа нь бага зэрэг өөрчлөгдсөн ч гэсэн тэр нь түүний хөлийн өвчнөөс болсон юм шүү. Тэр залуухан эхнэртэй бас нэг хүүтэй гэдгийг санаж яваарай. Түүнийг олиг муутай нэрээр нь дүгнэх гэсний хэрэггүй.
- Би тэндээс явахдаа ахмад Ахабын тухай бодсоор бүхий л оюун санаа минь хөвчирч байлаа.



## Дөрөвдүгээр бүлэг

### Далбайгаа босголоо

Бид Пекүдийн тавцан дээр гарахад ахмад Пелг биднийг зогсоогоод,

- Чи надад Кюкегийг махчин гэж хэлээгүй шүү дээ, - хэмээн ихэд цочирдсон хоолойгоор хэлэв, - Бид иймэрхүү бөө мөргөлтнүүдийг зөвшөөрдөггүй. Чамд тэгээд Кюкегийг Христийн шүтлэгтэн гэж итгүүлэх бичиг баримт байгаа юм уу? гэлээ.

- Тэр бол анхны сүмийн гишүүдийн нэг.

- Чи Деакон Күдмэний ажиллуулдаг сүмийг хэлж байна уу? Би тэр цуглаанаар ням гариг бүр орж гардаг, тэгэхдээ түүнийг нэг удаа ч болов харж байгаагүй юм байна. Чи намайг хуурч дөнгөнө гэж санаж байна уу?



- Сонсооч, тэр бол төрөхдөө Деаконий гишүүн байсан. Бүр өөрөө Деакон гэсэн ч болно.

- Ингэхэд чи ямар сүмийн талаар яриад байна? хэмээн ахмад хэлэхэд би өөрийгөө басамжлуулж байгаа юм шиг санагдан,

- Тэр бол энэ дэлхийд байдаг анхны сүм. Та бид хоёроос эхлээд бүхий л ээжийн хөвгүүд тэр сүмд явдаг – ертөнцийн хамгийн анхны сүсэгтний сүмд. Бид бүгдээрээ л тэр сүмд хамаатай.

Магадгүй бид хоорондоо өөр өөрийн гэсэн бяцхан ялгаатай байх л даа. Гэхдээ бидний гарыг сүр жавхлант, итгэлт нэг л Бурхан нэгтгэдэг юм гэлээ.

- Би хэзээ ч ийм гайхалтай номлол сонсож байсангүй. Магадгүй чи энэ онгоцон дээр шашин дэлгэрүүлэгч болж болохгүй юу. Гэхдээ надад хэлээч, чиний кюкег найз урьд нь загас жадалж байсан уу? гэж Пелг асуухад Кюкег тэр асуултыг нь ойлгов бололтой, яг л шалгалт өгөх гэж байгаа юм шиг дээр өлгөөстэй завинуудын нэгэн дээр авиран гарав. Тэгээд жадаа шидэхдээ,

- Ахмад аа, та тэр усан дээрх бяцхан толбыг харж байна уу? Тэгэхээр, түүнийг халимын нүд гээ гээд нүдний өмнө гялалзан харагдах өнөө хар толбыг сүлбэж орхилоо.

- За одоо! - гэж Кюкег бүх зүйлс яг үнэнээсээ болчихсон юм шиг хэлээд, - Тэр халим үхсэн! гэв.

Пелг түүнийг ажилд авахын тулд нэг их хугацаа зарсангүй, харин Кюкег гарын үсгээ зурахын оронд гар дээрх шивээсээ хуулбарлан зурав.

Бид Пекүдээс буугаад алхаж явтал гудамжаар ганцаараа гүйж явсан нэгэн хачин эр биднийг зогсоох нь тэр. Түүний хувцас нь тамтаггүй урагдаж цоорсноос гадна нүүр нь их муухай толботон цоохортжээ.

- Тэр онгоцныхонтой, та нар тэр онгоцныхонтой хамтран ажиллахаар болсон юм уу? гэж тэр хүн яг л жад шидэх гэж байгаа юм шиг Пекүд рүү хуруугаараа чичлэн асуулаа.

- Тиймээ, бид дөнгөж саяхан гарын үсгээ зурчихлаа.

- Тэр гэрээнийх нь цаасан дээр таны сүнсний талаар ямар нэгэн зүйл байсан уу?

- Бидний юу гэнэ ээ? хэмээн би ихэд гайхан асуув.

- Чамд тэгэхээр хэлээгүй юм биз дээ? Хүслэнт зорилгодоо хүрэхийн тулд хангалттай баг бүрдүүлсэн байх шив, тэгсэн байх нь... Хөгшин аянга...

- Хөгшин аянга гэж хэнийг...?

- Мэдээж хэрэг Ахаб. Чи түүний талаар ер нь юу мэдэх вэ?

Яригч этгээдийн ухаан жаахан муудсан мэт харагдах авч, би түүний асуултад хариу хэлэв.

- Тэр мундаг сайн халим агнагч, бас мэдээж үнэхээр сайн ахмад.

- Таны хэлсэн хоёулаа үнэн шүү. Гэхдээ өөр нэгэн зүйлийнх нь талаар юу хэлэх бол?... За за, ер нь энэ тухайд санаагаа бүү чилээгтүн. Учир нь та бүхний нэр тэр цаасан дээр аль хэдийнэ бичигдчихсэн шүү дээ. Зарим далайчид болон бусад хүмүүс түүнтэй хамт явах л хэрэгтэй болдог байх даа. Бурхан тэднийг өршөөг. Ингэхэд өглөөний мэнд, эрхмүүд ээ, диваажин та бүхнийг ивээг.

- Та биднийг мэхэлж чадахгүй, ямар нэгэн нууц мэдэж байгаа тань илт байна. Танд ч бас өглөөний мэнд хүргэе гэхэд минь тэрээр юу ч хэлсэнгүй, зөвхөн,

- Өглөөний мэнд, та нарт өглөөний мэнд хүргэе гэсээр замаа хөөн одлоо.

- Алив, Кюкег минь, наад өвчтэй хүнийг чинь орхицгооё, - гэснээ би сайхь хүний хойноос, - Эрхэм ээ, эрхэм ээ, та бидэнд нэрээ хэлээч! гэхэд

- Элижа гэсэн хариу сонсдов.

Кюкег бид хоёр цааш алхах зуураа тэр нооройсон хөгшин далайчныг зүгээр л нэг худалч этгээд байсан гэдэгтэй санал нэгдэж байлаа. Гэвч түүний тэр Элижа гэдэг нэр надад нэгийг бодогдуулав. Библид гардаг Элижа гэгч нэр бол муу зүйлийг зөгнөгч зөнчид байдаг билээ.

Пекүд гурван жилийн туршид хэрэглэх бараагаа базаах хүртэл бид хэдэн өдөр хүлээх хэрэгтэй болов. Ахмад Ахабтай уулзах гэж асуух болгонд “Түүний бие сайжирч байгаа, тэр удахгүй буцаж ирнэ” гэсэн адилхан хариулт сонсоно. Бид замд гарна гэдэг яриа сонсох хүртэл би түүний барааг хараагүй л байв. Гурван жилийн турш танихгүй ахмадын дор үйлчилнэ гэхэд миний дотор эвгүй мэдрэмж төрнө.

Кюкег бид хоёр онгоцны зогсоол дээр ирэхэд өглөөний зургаан цаг болж байлаа. Өмнүүр хэдэн усан цэрэг гүйн өнгөрөх шиг болсон ч өглөөний манан дунд тийм сайн ялган харж харсангүй. “Зогс” гэсэн дуу гарч, бидний мөрөн хэн нэгэн гараа тавих нь бид хоёрт адилхан мэдрэгдэв. Тэр бол Элижа байлаа.

- Та нар энэ онгоцон дээр суухгүй биз дээ?

- Бид суух гэж байгаа. Гэхдээ энэ танд хамаагүй биз дээ.

- Та хоёр тун саяхан онгоц руу гүйж явсан хэдэн хүнийг харав уу?

- Тийм ээ, гэхдээ тэдний яг хэн болохыг олж мэдэхэд хэтэрхий их манантай байлаа.

- Үнэхээр бүүдгэр, үнэхээр бүдэг байна. Гэхдээ одоо тэднийг олж харж чадах эсэхээ үз... Өглөөний мэнд хүргэе. Гэхдээ, эрхэмүүд ээ, ахиад би та нартай уулзахгүй л болов уу... Энэ түүний сүүлчийн үгс байсан юм, учир нь тэр яах ийхийн зуургүй биднийг орхин одлоо.

Пекүд зангуугаа өргөн ахмад Пелгийн удирдлага дор далайд гарлаа. Бид далайд гарах үед нэг бяцхан завь ирж, Пелгийг аван далайн эрэг өөд буцав. Кюкег бид хоёр ахмад Ахабыг одоо хүртэл хараагүй боловч багийн бусад гишүүдтэй танилцаж амжив.

Багийн толгойлогч Старбак: туранхай, тайван тогтуун тэрээр надад их л зоригтой нэгэн мэт харагдав. Гэхдээ жинхэнэ утгаараа шүү. Тэр аавыгаа болон ахаа далайд алдаж байсан болохоор ямар нэгэн тэнэг эрсдэл гаргах хүн биш ажээ. Багийн хоёрдугаар гишүүн Стабб, маш найрсаг, эрэлхэг зоригтой бас тасралтгүй тамхи татах авай. Хэрэв түүнтэй хамт жаахан удвал түүний царайг хамаргүйгээр, оронд нь бяцхан хар гаанстайгаар төсөөлөх болно. Пласк бол багийн гурав дахь гишүүн. Энэ намхан, пагдгар далайчны хувьд зүгээр л зугаацах гэж

халим агнадаг юм шиг санагдана. Өмнөд Америкийн зүүн хэсэг дэх Нөмрөг хошуу руу хийсэн аялал түүний хувьд жирийн нэгэн хөгжилдөөн, бяцхан инээдэм байх шиг санагдсан юм. Тэд гурвуул Пекүд дээрх халим агнуурын бяцхан завиудыг нэг нэгээр удирдна. Завь болгон өөр өөрсдийн жад шидэгчтэй байлаа. Ахмад далайчин Старбак Кюкегийг сонгож, Масачуссэтийн энэтхэг Таштего хоёр дахь гишүүн Стаббтай нэгдэж, харин Дагтоо нэрт аварга том, африк далайчин Пласкийн жад шидэгч болов. Гурван гишүүн ээлж ээлжээр багийнхныг удирдаж байсан авч Ахабын талаар ямар нэгэн сураг гарсангүй.

Цөөхөн хэдэн өдрийн дараа бид Нантукетыг орхилоо. Өдрийн харуулд томилогдсон би хөлгийнхөө тавцан дээр гарч ирэв. Гэв гэнэт бие чичрэх шиг болов... түүнийг олж харлаа.



Уйтгартай нь аргагүй зогсох Ахаб надад өндөр хүрэл хөшөө шиг санагдсан юм даа. Нарийхан цагаан сорви саарал үсийг нь сүвлэн, нүүрнийх нь баруун талаар, цаашлаад хүзүүгээр нь доошилж, хувцсан доогуур нь шургатал үргэлжилжээ. Тэр сорви яг л нэгэн сүрлэг сайхан мод аянгад ниргүүлчихсэн юм шиг харагдана. Гэхдээ одоо хүртэл амьд явж байдаг...бас тамгалуулчихсан. Түүний нэг хөлийг халимын эрүүний шув шулуухан ясаар хийсэн байлаа.

Түүнийг онгоцны энэ их чичиргээнд яаж ясан хөлтэйгөө ийн тогтож байгаад нь гайхсан хэдий ч удсангүй учрыг нь олох шиг болов. Удирдагч нарын тавцан дээр энд тэндгүй хагас инчийн хэртэй нүх байдаг нь түүний ясан хөл яг тэнд таарч, онгоцны донсолгоо бүрт чимээгүйхэн тэнцвэртэй зогсож бүхнийг ажиглахад тусалдаг аж. Ахмад Ахаб их зовиуртай, мөн харууслаар дүүрэн нэгэн мэт харагдав.



## Тавдугаар бүлэг

### Моби Дикэд үхэл!

Онгоц маань өмнө зүг рүү чиглэсээр халуун орны уур амьсгал руу цөмрөн орлоо. Ахмад Ахаб тавцан дээр байнга л үзэгдэх болж, нүх гаргасан зангуун сандал дээрээ нөгөө л аргаараа тухална. Заримдаа тэрээр тавцан дээр гуйвж дайван үзэгдэх агаад заримдаа ийш тийш алхах ясан хөлийнх нь чимээ шөнө биднийг сэрүүн байлгаж чаддаг байв.

Нэг удаа Стабб тоглоомоор,



- Өнгөрсөн шөнө түүнийг тавцангаар нэг жороолж байгааг нь мэдэрсэн хэмээн өгүүлэхэд Ахаб түүн рүү эргэн хараад,

- Доошоо бол, нохой минь, тэгээд нохойн хороо руугаа тонил! хэмээн хашгирав.

Стабб хэсэг зуур хэл нь татчихсан юм шиг байснаа,

- Ийм өнгөөр ярилцахад би дасаагүй юм. Надад хэн нэгэн ингэж хэлүүлж хандахад би дургүй, эрхэм ээ. Энэ үнэхээр надад таалагдахгүй байна гэлээ.

- Тэгвэл арван удаа илжиг гэж дуудуулаад, цаашаа тонилж үз. Эс тэгвээс таныг би хорвоогоос тонилгочихож дөнгөнө шүү хэмээн Ахаб түүн рүү заналтай хашгирлаа.



Стабб ухран, түүнээс холдоод, тэнд байсан залууст хандан,

- Би түүнийг цохиод авах уу, аль эсвэл түүний төлөө залбирал үйлдэх үү? Тэр солиотой юм байх даа? Тэгээд бас шөнөжин юу боддог болохоороо өдөрт гуравхан цаг унтдаг байна аа? Тэр унтахгүй байгаа ч гэсэн Стюард хэлэхдээ ор нь үргэлж л ундуй сундуй болж, дэр нь үргэлж зуухнаас гарсан тоосго шиг халуун байдаг гэсэн. Тэр үнэхээр оньсого шиг нэгэн юм гэсээр явлаа.

Өглөөний цайны дараа Ахабын алхаа ерийнхөөрөө л сонстож байсан хэрэг. Тэр өглөө гэхдээ ясан хөлийг нь тавцан дээр тогтоох өнөөх цөмөрхийнүүд ердийнхөөс гүн харагдаж байсан юм шүү. Магадгүй тэр сандарсны улмаар илүү гүн гүнзгий мөр үлдээсэн биз. Үргэлж сэрүүн байлгахад хүргэдэг бодлуудынх нь нэгнээс болж, дух нь дэндүү их үрчлээтжээ.

Бүхий л өдрийн туршид тэр тавцан дээр холхив. Нар жаргахын өмнө тэр гэнэтхэн тавцанг голлон зогсоод Старбакт хүн бүрийг цуглуулах тушаал өглөө. Багийнхан онгоцныхоо хойд хэсэгт гэнэт бөөнөөрөө цугларах тэр хачин тушаалд гайхсан нь мэдээж.

Биднийг хоорондоо тэр тухай шивнэлдэж байгааг ч үл хайхран Ахаб тавцан дээгүүр нааш цаашаа үргэлжлүүлэн холхисоор л. Эцэст нь,

- Эрчүүд ээ, та бүхэн халим хараад хамгийн түрүүнд юу хийдэг вэ? гэж тэр асуулаа.

- Түүнийг ямар нэгэн дуу авиа гарган дууддаг хэмээн нэг нь хариулав.

- Сайн байна, харин дараа нь?

- Түүнийг ажиглаж, араас нь дагадаг.

- Эрчүүд ээ, та бүхэн завиа сэлүүрдэхдээ ямар дуу аялдаг вэ?

- “Үхсэн халим”, эсвэл “Халуун завь”!

Ахаб хүн дор бүрээс хашгирах дууг ихэд сайшааж байсан ба нүүр нь аз жаргалаар дүүрэн гэрэлтэнэ. Тэр нэг гялтгар зоос гаргаж ирснээ, алх авчир хэмээн тушаав.

- Үүнийг харцгаа. Та бүхэн энэ алтан испани зоосыг харж байна уу? Та бүгдийн дотроос хэн нь анх үрчгэр магнай, муруй эрүүтэй цагаан толгойт халимыг олсон нь... толгойдоо гуч хол даван цоолуулж байсан тэр халимыг харсан нь... Үүнийг харцгаа, хэн тэр цагаан халимыг харна, тэр энэ алтыг авах болно, хөвгүүд минь гэлээ.

Ахабыг алтаа онгоцны хананд хадаж байх зуур далайчид “Ура, ура” хэмээн хашгиралдаж байв.

- Миний хэлсэн шиг тийм нэг цагаан халим байгаа. Та нар цагаан ус хайн сайтар ажиглаарай, хөөснөөс өөр ямар нэгэн юм харвал сайтар тогтоон хараарай хэмээн Ахаб яриагаа үргэлжлүүлэв.

Тэр үед Таштего, Даггоо, Кюкег нар ахмадын үгийг багийн бусад гишүүдээс илүү сонирхсон янзтай харагдана. Үрчгэр магнай, муруй эрүүний тухай дурьдахад ямар нэгэн хуучин дурсамждаа автах шиг болов.

- Ахмад Ахаб, тэр цагаан халим нөгөө Моби Дик гэгч тань мөн байх аа? гэж Таштего асуув.

- Тийм ээ, Тааш. Чи тэгэхээр цагаан халимын талаар мэддэг байх нь ээ?

- Тэр шумбахаасаа өмнө сүүлээ хажуу талууд руугаа хөдөлгөдөг үү? гэж Таштегог асуухад,

- Бас түүний оргилуур нь их сонин, тэр их хурдан байх, тийм үү? гэж Даггоо нэмэв.

- Тийм ээ, тийм. Бас түүний арьсанд гурван төмөр нуугдаж байдаг, тийм үү, ахмад аа? Бас сорвитой, нэг тийм, орооцолдчихсон юм шиг... хэмээн Кюкег тэр сорвийг нь дүрслэх гэж оролдон гараа агаарт эргүүлэв.

- Зоригт эрс минь, тийм ээ Кюкег, түүний биеэр дүүрэн сорви байгаа. Тийм ээ, Даггоо, тэрний цорго нь асар том. Тиймээ Таштего, тэр сүүлээ шумбахаасаа өмнө үргэлж л тал тал тийшээ хүчтэй хөдөлгөдөг... Үхэл хийгээд тамын чөтгөрүүд! Та нарын харсан тэр зүйл бол Моби дик, Моби дик! хэмээн Ахаб уйлах гэж байгаа юм шиг хэлэв.

- Ахмад Ахаб аа, Моби Дик таны хөлийг авсан биш билүү? гэж Старбак тэндээс асуув.

- Тийм ээ, миний одоо зогсож байгаа байдлыг буюу энэ үхдэлийн тамгыг тэр муу ёрын цагаан халим өгсөн юм. Би бууж өгөх хүртлээ түүнийг агуу их итгэлтэйгээр Нөмрөг хошуунаас эхлээд халуун там хүртэл мөрдөн мөшгөх болно. Ийм учраас та нарыг авсан юм аа, эрчүүд ээ, та бүхэн тэр цагаан халимыг хорвоогоор нэг хөөж, цоргоноос нь хар цусыг нь асгаруулж, өнхрөн унатал араас нь явах хэрэгтэй. Юу гэмээр байна, эрчүүд ээ? Та бүхэнд энэ агуу зүйлийг хийх хангалттай эр зориг байна уу? хэмээн Ахаб хашгирлаа.

- Тийм ээ, тийм! гэж далайчид болон жадчид хашгирна.

- Та нарыг бурхан ивээг, эрчүүд ээ! - хэмээн Ахаб хагас уйлаанаар хашгираад, - Стюард, явж эрчүүдэд ром дарс авч ир!... гэв.

Энэ зуур дуугүй зогсож байсан Старбакийг хараад ахмад,

- Старбак, чи яагаад ийм баргар харагдаж байна вэ? Чи Моби Дикийг мөшгөхгүй юм уу? гэж асуухад,

- Бид халимаас олз ашиг хайх гэж энд ирсэн болохоор түүний тэр тахир эрүү болон сүр дуулиантай үхлээс нь айгаад байх зүйл алга. Гэхдээ би энд халим агнах гэж ирсэн болохоос ахмадынхаа өшөөг авах гэж ирээгүй гэдгээ л мэдэж байна гэж тэр өгүүлэв.

Старбак ганцаараа ахмадын эсрэг зогслоо, гэхдээ тийм ч сүртэй эсэргүүцсэнгүй, “Бурхан намайг ивээг, бурхан бид бүгдийг ивээг” хэмээн аяархан дүнгэнэсээр байв.



Ахаб том гэгчийн тугалган аяганд ром дарс дүүргэн “Уугаад дамжуулцгаа” хэмээн хашгираад хамгийн ойр зогсож байсан далайчинд өгөв.

- Овоохон балгацгаа, эрчүүд ээ, энэ яг л чөтгөрийн туурай шиг халуун байна... сайн байна, бараг л хоосолчихлоо. Стюард дахиад дүүргэ...

Дараа нь тэр нөгөө багийн гурван гишүүнийг урагш нь гаргаад,

- Жаднуудаа зөрүүлэн барьцгаа. Миний загасчин өвөг дээдсийн үеэс уламжлагдаж ирсэн тэр сайхан сүр жавхлант заншлыг би та нарын жадаар сэргээн үзүүлье гээд гурван жадыг гартаа авав.

Тэгснээ Старбакаас Стабб, Стаббаас Пласк хүртэл өөрийнхөө урам зоригт хүслийг тэдний зүрхэнд бадрах гэж байх мэт нэвт ширтэнэ. Багийнхан түүний тэр хүчтэй бөгөөд нууцлаг ширтэлтээс шивээтэн харцаа буруулав.

- Жаднуудаа буулга! - гэж эцэст нь тэр хэлээд Кюкег, Таштего, Даггоо гурав руу эргэн харж, - Харин одоо миний баатарлаг гурван жадчин минь ээ, жадныхаа төмөр үзүүрийг сугалан авцгаа! гэлээ.

Кюкег, Таштего, Даггоо гурав жадныхаа үзүүрийг сугалан авч, нүхтэй талыг нь дээш харуулан барьцгаав.

Ахаб тэдгээрийг нь хоосон хундага мэт дүүргэх зуураа,

- Ууцгаа, Моби Дикэд үхлийг авчрах дайчид минь. Моби Дикийн үхлийн төлөө ууцгаа, бас тангараглацгаа. Хэрэв бид Моби Дикийг олж, үгүй хийж чадахгүй бол бурхан биднийг гэсгээг! хэмээн тэр тушааж байсан юм.

# Зургадугаар бүлэг

## Таван хий үзэгдэл

Би ерөнхийдөө халимын тухай, ялангуяа Моби Дикийн талаархи бүх төрлийн мэдээллийг цуглуулж эхэллээ. Хамгийн өндөр үнэтэй халим бол стери халим. Учир нь түүний толгойн хэсэгт байдаг спермакет хэмээх цагаан өнгийн лав шиг зүйл нь асар үнэтэй аж. Спермакет нь бүх төрлийн дэнлүүг гэрэлтүүлэхэд болон сүрчиг хийхэд чухал түүхий эд болдог юм байна.

Би Моби Дикийг маш холоос таньж болдгийг олж мэдэв. Учир нь тэр бусад спери халимаас маш их ялгаатай, тэр зөвхөн цасан цагаан өнгө, магнайн дахь үрчлээс, өндрөөс өндөр бөгтөр нуруу зэргээрээ ялгараад зогсохгүй ажээ. Аварга том биедээ цагаан өнгийн ижилхэн ижилхэн бидэртэй нь алдарт цагаан халим гэдэг нэрийг зүүхэд хүргэсэн биз. Моби Дик өөрийг нь нэхэж буй ангуучид руу хэрхэн дайрахаа мэддэг байлаа. Тэр эхэндээ айж буй дүр үзүүлэвч гэнэт дайснууд руугаа эргэн довтолж завийг нь эвдэн бусниулах, эсвэл хүмүүсийг онгоц руу нь аюумшигт автуулан буцаадаг гэнэ.

Дээр үед юмсанж, нэгэн ахмад түүн рүү багийнхантайгаа гурван завиар явжээ. Тэр гурван завийг гурвууланг нь цагаан халим хэмхэлж, эрчүүд нь далайн эргүүлэгт өртөж байхыг хараад ахмад нь зургаан инчийн урттай жижигхэн хутгаа шүүрэн авч, халз тулаанд оролцож буй зэрлэг хүн шиг Моби Дикийн зүрхийг чиглэн үсрэв.

Тэр мөчид халим ахмадыг тахийсан эрүүгээрээ шүүрэн авч өрөөсөн хөлийг тасар татаж орхижээ. Тэр ахмад нь Ахаб байсан юмсанж. Тэр мөчөөс эхлэн Ахаб халимд өс өвөрлөх болж, ертөнцийн бүхий л муу ёрын юмсыг тэр халимаар төсөөлөх болов. Би тэр хүнийг өөрийнхөө өс хонзонг тэднийх мэт болгон багийнхантайгаа хуваалцаж чадсанд нь гайхаж байлаа.



Тэр шөнө бид сарны гэрэлд зэрэгцэн зогсоод өдрийн хэрэгцээний цэвэр усаа хувингаар зөөж, торхонд юулж байсан юм. Гэнэт нэг далайчин,

- Чишш, энэ чимээг сонсож байна уу? хэмээн шивнэв.

- Ямар чимээ?

- Тээр, дахиад дуугарлаа. Сонсож байна уу, тавцан дороос. Энэ нь хэн нэгэн ханиаж байх шиг сонсогдох адилхан юм.

- Тайван бай, найз минь, энэ зүгээр л оройн хоолондоо идсэн гурван ширхэг жигнэмэг гэдсийг чинь дүүргэж байгаагаас зайлахгүй. Норчихоод байсан болохоор л тэр. Одоо наад хувингаа түргэн аваад өг.

- Чи хүссэнээрээ л даажигнан инмээсэглэ, юу болохыг нь харж л байя. Тэнд тавцан доор хэн нэгэн байгаа гэдэгт би итгэлтэй байна. Ахаб ч гэсэн үүний талаар мэдэж байгаа байх.

Стабб нэгэн өглөө Пласкт салхинд ямар нэгэн юм байна гэж хэлэхийг сонссон.

Гэвч энэхүү нууц явдал цааш өрнөсөнгүй. Шураг дээр харуулд гарч байсан Таштего “Тэр тэнд явна” гэж хашгирав. Би тэр индианы заасан газарт халим олж харахаар яаравчлав. Таштего тэртээ өндөрт зогсох агаад гар нь яг л саваа мэт сунасан харагдана.

- Тэр тэнд, тэнд, тэнд явна! Тэнд, тэнд! хэмээн бахирна.

- Хаана? Хаана? хэмээх сэтгэл хөдөлсөн дуу энд тэндээс гарлаа.

- Тэр гэрэл хавьцаа, ойролцоогоор хоёр бээрийн цаана, тэд сүргээрээ явж байна! гэх түүний үг тэд салхины эсрэг талд байна гэсэн утгатай байсан тул далайчид бүгд шуугилдаж, хөл хөдөлгөөнд орж эхлэв.

- Хурдал Стюард, намайг даруйхан тийш хүргээд аль! гэж Ахаб хашгирахад Стюард доошоо хурдалж, цаг харж ирээд яг хэдэн цаг, хэдэн минут болж байгааг нарийн тодорхой уламжлав.

Бид Ахаб хаана, хэзээ халим олж харсан, эсвэл агнасан тухай нямбайлан бичсэн тусгай тэмдэглэлтэйг нь мэднэ. Шөнө бүр тэрээр түгжээтэй хайрцагнаасаа үрчийлгэн хуйлсан том гэгчийн далайн бүдүүвч зураг гаргаж ирээд олон янзын зураас, зам чиглэл зэргийг тайвнаар судлан, харандаагаар тогтмол тэмдэглэдэг байлаа. Тэрээр дөрвөн далайн бүхий л урсгал, түүний судал, бүх халимуудын зуршил зэргийг өнөөх л Моби Дикийг алахын төлөөх цорын ганцхан, галзуурсан зорилгодоо хүрэхийн тулд судладаг байв.

Гэсэн ч бид яг одоо өөр халимын хойноос хөөцөлдөж байна. Энэ бүгдийн дараа Пекүд гол ажил руугаа буюу Ахабын бүхий л оюун бодол болох жинхэнэ олз руу явна гэдгийг би мэднэ.

Онгоц маань шуурганаас болгоомжилж байсан ч гурван завь онгоцноос савлан гарч, далайд буулаа. Яг тэр сэтгэл хөдлөм агшинд гэнэт хашгирах мэт чимээ сонстов. Ингэмэгц хүн болгон халим руу бус тэнд байгаа Ахаб руу харцаа хандуулав. Ахмад тавцан дээр сууж, түүнийг тойрон бараан өнгөтэй таван хий үзэгдэл аятай юмс эргэлдэнэ. Тэгснээ тэр ер бусын зүйлс яах ийхийн зуургүй нэг завь буулгаж байлаа.

- Бүгд бэлэн үү, Педалла? гэж Ахабыг дуугаргахад,

- Бэлээн! – гэх хагас шивнэсэн дуу ган илд шиг ганц шүд, төмөр уруултай юм уу гэмээр өндөр харанхуй хүнээс гарлаа. Тэрээр үрчгэр хар даавуун өмд, хүрэмтэй ба урт цагаан үсээ сүлжин толгойдoo яг л алчуур шиг ороожээ. Бусад эрчүүд нь Австралийн ойролцоо байх Пиллипин арлын Манилла овгийнхны бар шиг шар алаг өнгийн зүүсгэл өмссөн байлаа. Зарим мухар сүсэгт далайчид тэр нутгийн ардуудыг чөтгөрийн нууц тагнуул гэдэгт итгэдэг аж.

- Доошоо буулга! гэж ахмад Ахаб хашгирлаа.

Эрчүүд ганхаж буй онгоцноос яг л ямаа шиг шалмаг бууж байв. Дөрөв дэх завь өнөөх Ахабыг тойрч байсан хачин жигтэй таван зүйлийн шингээж одсон ба түүн дээр суусан Ахаб аль болох ахиухан газрыг хамрагтун хэмээн Старбак, Пласк, Стабб нарын араас хашгирч байлаа. Нэг минутын орчмын турш Стабб, Старбак хоёрын завь нэг нэгэндээ ойртож ирэв.



- Тэнд байсан өнөө таван зүйл юу байсан юм бол оо? гэж Стаббыг асуухад Старбак,

- Онгоц хөвөхөөс өмнө тавцан дээр хулгайгаар гарч ирсэн этгээд л биз. Хүчтэй сэлүүрдээд өгөөрэй, хөвгүүд ээ. Энэ их гунигтай ажил шүү, ноён Стаб, гэхдээ битгий санаа зов, үүнийг зөвхөн сайн сайхны төлөө л хийж байгаа юм гэлээ.

- Би ч гэсэн ингэж бодсон юм аа. Ийм болохоор л ахмад тавцан доогуур олонтаа ордог байжээ... Үүний цаана өнөө цагаан халим... За, за одоо ийм юм ярих цаг биш. Юутай ч өнөөдрийнх цагаан халим биш байж.

Би Нантукетийн манант үүрээр Пекутын тавцан дээр мөлхөн гарсан хий үзэгдэл мэт эрчүүдийн тухай, бас өнөөх Элижа хэмээх хачин эрийн учир битүүлэг сануулгын тухай чимээгүйхэн эргэн саналаа. Үүн шиг сэтгэл хөдөлмөөр үйл явдал тулчихаад байгаагүй бол надад бодох юм их байсан даа. Гэвч одоо бидний өмнөө тавиад байсан хамгийн чухал зорилго бол алим агнахад байсан билээ.



## Долдугаар бүлэг

### Хүмүүс завинаасаа шидэгдэв

Ахабын бар шиг шар эрчүүд халимын араг яс шиг, эсвэл төмөр шиг харагдацгаана. Мөн тэдний дээш доош савчих сэлүүрүүд туйлын хүчтэй тачигнах таван алх мэт ажээ. Завины сүүлэн дээр сууж явсан Педалла Ахабын завийг анчдын сэлүүрээр ийш тийш нь холбилзуулалгүй тун шаламгай жолоодож явна.

- Пласк, илүү нөмөртэй газар руу ойртуул! хэмээн Ахаб бусад бүх завийг хамруулан хөндлөн гулд хашгирлаа.

- Ойлголоо эрхэм ээ, - хэмээгээд Пласк өөрийнхөө сэлүүрийг эргүүлэн, - Хойшоо бай, хойшоо бай, эрчүүдээ, бидний яг өмнө халимын оргил харагдаж байна, хөвгүүд ээ! Аянгат сумнууд минь, түүн рүү ойртоцгоо! хэмээн хашгирав.



Энэ хооронд өөр завинд явсан Стабб багийнхнаа мөн л сэлүүрдүүлж эхэлсэн авч огт өөрөөр, хөгжилтэй маягаар ажлаа явуулж байв. Бараг солиотой гэмээр үгсийг уурласан ч юм шиг, тоглосон ч юм шиг өнгөөр хэлнэ. “Татаад байгаарай, татаад байгаарай, жаалууд минь, яагаад та нар ар нурууныхаа ясыг хуга татчихгүй байгаа юм бэ? Завин дээр яваа тавьд битгий анхаарлаа хандуул. Тэд чөтгөр ч гэсэн бидний найзууд. Уухай, алтан аяган дахь спер тосонд баяр хүргэе. Бүгдээрээ унтаж орхисон байх чив ээ, золигнууд минь. Сэрцгээ! Сэлүүрдэцгээ.

Ээж бүхний хөвгүүд ээ, хутгаа гаргаж, шүдэндээ зууцгаа. Одоо арай дээр боллоо” гэнэ.

Завинуудын нэгийг хөлөглөж явсан Старбакийн арга бүр ч өөр байсан юм. Хоолойныхоо доод өнгөөр “Сэлүүрдээд байгаарай, сэлүүрдээд байгаарай, сайн хөвгүүд минь” хэмээн сулхан шивэгнэнэ. Тэр багийнхандаа өөр юу ч хэлсэнгүй, багийнхан нь ч мөн адил юм дуугарсангүй.

Архиран сүржигнэх далайн давлагаа завинуудыг ийш тийш нь шидэлж, хуй салхины аясаар усан толгодын орой өөд гаргаснаа дахин доошоо чаргаар гулгаж байх шиг бууцгаана. Юм бүхнийг энд тэндгүй дураараа чулуудах далайн энэ араншин бүхэл бүтэн гайхамшиг бас айдас бишрэл байлаа. Тэр бүхний дунд ангуучдын хашгирах дуун дотор зарс хийлгэнэ. Багтран орилох хоолой л энэ тэндгүй сонстох аж... Пекүд яг л орь дуу тавин дэгдээхэйнийхээ хойноос гүйх зэрлэг эх тахиа шиг завинуудынхаа араас явж байна.

Старбак ийнхүү гурван халим хөөж байх зуур манай завинууд улам ширүүсэн буй шуургыг сөрөн хурдалж явлаа. Гэтэл хэн нэг нь Кюкегт “Дээшээ бос!” хэмээн шивнэв. Жад шидэгч маань хөл дээрээ босон, “Түүний сэрвээ тэр байна. Тийшээ шид” гэж хэлэхийг нь хүлээж байлаа.

Кюкегийн шидсэн жад шунгинах дуу гаргасаар урагшаа гулсан одов. Гэв гэнэт юу болж байгаа нь үл мэдэгхэн үймээн дэгдэв. Нэгэн дийлдэшгүй түлхэлт манай бяцхан завины араас орж ирлээ. Завины маань дарвуул нуран унаж, яг л газар хөдөлж байх шиг бидний дор ямар нэгэн юм өнхрөн эргэлдэв. Ингээд бид цөмөөрөө далайн цагаан хөөс рүү шидэгдэн орлоо. Шуурга, халим, жад гурав гурвуулаа нэгдэж, жадлуулсан халим зугтаж одов.

Бид ийш тийш сэлэн, хөглөрсөн сэлүүрүүдээ түүж аваад хоосон байгаа завь руугаа эргэж очлоо. Ойр хавьд байсан бусад завинуудаа дуудаад ч нэмэр алга, шуурган дунд хэн ч биднийг сонссонгүй. Завин дотор өвдгөөр татахуйц их ус орж ирсэн байна. Өтгөн манан дунд Пекүд хаана ч харагдана.

Үүр цайхад шалба норсон бид ямар ч итгэл найдваргүй болчихоод чичирч суув. Гэтэл Кюкег хамгийн түрүүн үл хөл дээрээ үсрэн босоод гарынхаа алгыг хумин чихэн дээрээ аваачлаа. Бид түүнийг дуурайн юу болж байгааг сонсоход чихрах мэт сулхан дуу сонстов. Бид юу болоод байгааг ойлгохоос урьтан Пекүд маань нүдний өмнө сүүмэлзэн гарч ирлээ. Пекүдийн их биед завь бут цохигдохоос өмнө бид далай руу үсэрч амжив. Хөлгийн тавцан дээр гарах хүртлээ тэр их далайд бид дахиад л амь амиа бодон сэлж явлаа. Нөгөө гурван завь маань хөлөг дээр цагтаа буцаж очсоныг бид мэдэв.



Дотны анд Кюкегээсээ энд иймэрхүү зүйл олон тохиолддог уу гэж би биеэ сэгсрэх зуураа асуулаа. Тэр надад “тийм” гэдгийг ойлгуулах гэсэн бололтой толгойгоо тайван дохив. Стабб, Пласк хоёр ч гэсэн үүнтэй санал нийлж байна. Тэр гурав завь хөмрөгдөх тухай юу ч тооцоолоогүйг бодоход, бас шуурган дунд ноён Старбакийн халимын шүд рүү орох гэж байсан болгоомжгүй үйлдэл нь ердийн биш байсныг бодоход, мөн ахмадын цагаан халим хайх солиотой эрлийн талаар бодоход надад хийвэл зохих ухаалаг алхам цорын ганц байх шиг санагдлаа.

Би доошоо бууж, гэрээслэлийнхээ анхны хувилбарыг боловчруулахаар явахдаа “Надтай хамт явж, зөвлөгч минь болооч” гэж Кюкегийг урив.

## Наймдугаар бүлэг

### Моби Дикийн золиос

Сайхан Найдварын Нөмөр гэдэг нэр нь их л андуу ташаа өгөгдсөн болов уу гэмээр ёолон гинших салхи, үсрэн цохилох давлагаатай тэр газраас зүүн өмнөд зүгт бид өөр нэгэн хөлөг онгоцтой таарлаа. Гэрээсээ гараад нэлээд удсан шинжтэй, уртаас урт сахалтай, хуучирч урагдсан налмагар хувцастай далайчид бүхий, хана нь энд тэндгүй зэвэрсэн Албатросс хэмээх хөлөг байв.

- Сайн байна уу, хөлөг онгоцныхоон? Та бүхэн цагаан халимыг харав уу? хэмээн Ахаб ахмадаас нь асуухад Албатроссын ахмад хариу өгөхөөр чанга яригчаа амандаа ойртуулах гэж байгаад түүнийгээ далай руу унагаасан тул хариу өгч чадсангүй.



Тиймээс бид өнгөрөн одлоо.

Нэг их удалгүй бид гэр лүүгээ буцаж яваа өөр нэг халим агнуурын онгоц Таун-Хьютэй таарав. Энэ удаа Ахаб зорчигчдоо солилцохыг зөвшөөрсөн тул Таун-Хьюгийн зарим эрчүүд Пекүдийн тавцан дээр зочлох зуураа өөрийн онгоцны зарим нууцын талаар Таштегод шивнэж амжив. Сонссон бүхнээ Таштего дараа нь бидэнд ярихад Моби Дик бидний анхаарлыг илүү их татсан юм.

Таун-Хьюгийн офицертэй нэг далайчин тавцан шүүрдэх шударга бус журмаасаа болоод

тэмцэл гаргажээ. Өөрийгөө хамгаалахын тулд далайчин толгой дундуур нь цохин ухаан алдуулжээ. Бусад нь үүнд бас татагдан оролцож, улмаар бослого гарсан гэнэ. Скиллкилт хэмээх далайчин багийнхаа толгойлогч Радниг алах гэж байтал Моби Дик үзэгдсэн тухай дуудлага иржээ. Раднигийн завь хамгийн түрүүн буулгагдахад тэр гартаа жад барин зогсож байснаа гэнэт завины тавцан дээрээс унаж давлагаа руу хамагдан оржээ. Гэтэл аймшигт Моби Дик түүнийг амандаа зуугаад өндөрт цоройж ирснээ ус руу аваад орчихсон гэнэ. Халимыг дахин уснаас өндийхөд шүдэнд нь Раднигийн улаан болсон ноосон цамц үлдсэн байлаа. Тэнд байсан дөрвөн завь дөрвүүлээ түүний араас нэхсэн авч Моби Дик юунд ахин үзэгдэх билээ.

Таун-Хьюгийн түүхийг сонссоны дараа бид бүгдийн ухаан санаанд ганцхан Моби Дик л эргэлдэж байлаа.

Дагтоо нэг удаа харуулд гарч байгаад аварга том цагаан юм дээшээ гараад буцаж давлагаатай нийлээд байхыг харсан гэнэ.

- Тэр тэнд байна! Цагаан халим, цагаан халим! хэмээн тэр хашгирав.

Ахаб яах ийхийн зуургүй завиудыг доошлуулах тушаал өглөө. Түүний завь ахиад л нөгөө гурвынхаа урд оржээ. Маш том, бараг зуун яардын урттай, цөцгий шиг өнгөтэй зүйл усан дээр гарч ирэхийг би сонирхон харлаа. Тоолж баршгүй олон, яг могой шиг эргэлдэн мушгиралдах урт гарууд нь төв дундаасаа гарсан, нүүр гэхээр юмгүй, мөн ар тал ба урд талгүй, сүнс шиг огт хэлбэр дүрсгүй, амьд юм байлаа. Тэр алга болохдоо ямар нэгэн зүйл сорж байгаа юм шиг сулхан дуу гаргасаар явж одов.

- Би энэ цагаан сүнснээс илүү Моби Дикийн барааг сайн харах байжээ гэж Старбак надад хэлэв.

- Энэ юу байсан бэ, эрхэм ээ? хэмээн Пласк асуулаа.

- Тэр бол аварга том далайн арваалж. Далайн арваалжтай тааралдсан халим агнуурын онгоц хэзээ ч боомтдоо эргэж ирдэггүй гэцгээдэг.

Үүнийг сонсоод Ахаб юу ч хэлсэнгүй. Тэр эргэн, онгоц руугаа буцахад бид чимээгүйхэн түүнийг дагав. Гэхдээ Кюкег далайн арваалж харвал яадаг тухай өөр бодолтой байлаа. Түүнийхээр бол хажуугаар далайн арваалж өнгөрвөл удахгүй спери халимтай таардаг аж.

Дараагийн өдөр халуу шатаж эхэлсэн тул бид бүгдээрээ л хагас нойрмог өнжив. Гэтэл яг Кюкегийн хэлснээр үд дундын халуунд цоргоноосоо ус оргилуулах аварга том спери халим залхуутай сэлж явааг бид олж харлаа. Тэр халим үнэхээр үдийн халуунд тамхи татаж суугаа бүдүүн хүн шиг харагдана. Гэхдээ тэр нь хөөрхий халимын сүүлчийн тамхилалт байх биз ээ. Шидэт саваагаар дохиулсан юм шиг онгоцон дээрх нойрмог эрчүүд нэгэн зэрэг сэрж, завинуудаа яаран буулгав. Бидний дуу шуу тэр халимыг цочоосон бололтой, сүүлээ агаарт бараг дөчин футын өндөрт гаргаж ирэх нь нурж байгаа цамхаг мэт харагдав.

Халимын дахин гарч ирэх газарт Стабб бусдаасаа илүү ойрхон байсан болохоор түүнийг

агнах аз тохиож болох байлаа.

- Түүнийг тэнгэрийн дуу мэт цочооцгоо, эрчүүд минь. Гэхдээ тайван байцгаа, тэр бараг л тэнгэр ниргэсэн ч ажрахгүй шүү, түүнийг сэрээ Тааш, хүү минь гэж ахмад тушаана.

- Уоо- хүү! Хүү-хоо! хэмээн Даггоо хуучин цагийн индианы дайчин уриа хадаан тэнгэр өөд хандлаа.

Түүний зэрлэг хашгираанд бусад завинууд бас зэрлэг хашгирах дуугаар хариу барилаа.

“Хээ-хээ! Хээ-хээ!” хэмээн Даггоо торонд орсон зэрлэг барс шиг ийш тийш холхин хашгирав.

“Ауу-ауу, ауу-ауу” хэмээн Кюкег чоно шиг улилаа.

Стаббын завин дээр байсан эрчүүд хүсэн хүлээсэн хашгираагаа сонсох хүртэл цовхчин дэвхэцсээр л байсан юм.

- Таштего, босоорой! Түүнд үзүүлээд өг. Жадаа шид!

Жад шидэгдлээ. Завь маань буцалж буй усан дундуур аварга загасны сүрлэг сэрвээ шиг зүсэн орлоо. Тэр халим агшин зуур Атлант болон Номхон далайг бүтнээр нь туулчих шиг санагдав. Эцэст нь халимын сэлэлт удааширч, завинд ч бас амсхийх боломж олголоо.

- Татаарай! Татаарай! хэмээн Стабб хашгирч байна.



Хүн болгон халимыг хараад завиа түүн рүү ойртуулж эхлэв. Стабб халимын зүг хорт сумаа ар араас нь илгээсээр... Удалгүй тэр мангасын бүх биеэс улаан юм гоожиж эхэллээ. Нар цустай усан дээр тусаж, туяа гэрлээ тэнд байгаа хүн бүрийн нүүрэнд ойлгон тоглоход тэд бүгдээрээ улаан арьстнууд шиг цогшиж харагдана.

- Дээшээ татаарай! хэмээн Стабб бас хашгирна.

Завь урагшилсаар халимын дэргэд очлоо. Стабб гараа сунган нумаа тэмтрээд хурц иртэй урт жадаа халимын зүрх рүү алгуурхан шаагаад түүнийгээ тэнд удаан гэгч нь байлгаснаа дахин болгоомжтой бүлж эхлэв.

Тэр халим эцсийнхээ хөдөлгөөнийг хийж, галзуу хүчтэй шүршин завийг өөрөөсөө холдууллаа. Нэг их удалгүй шүршихээ больж, хөөрхий халим бидний өмнө сүүлийн удаа найгах шиг болоод цоргоныхоо нүхийг нэг хаан, нэг нээгээд эцэст нь амьсгалаа хураалаа. Улаан цусан ус агаарт оргилон, халим далай руу аажимхан доошлов. Түүний зүрх хагарчээ.

Стабб гаансаа амнаасаа аваад хөрсөн үнсийг нь усан дээр цацав. Дөнгөж сая өөрийнхөө гараар бий болгосон аварга том үхдэлийг гүн бодолд автсан нүдээр ширтэн зогсоно.

# Есдүгээр бүлэг

## Сүйрлийн солиотой зөнч

Стаббын авласан тэр олз хөлөг онгоцноос арай зайтай байсан болохоор Пекут руу аваачихын тулд гурван завиар чирч эхэллээ. Тэр аугаа том зүйлийг хөдөлгөх ажилд бидний гучин зургаан гар нэг зуун наян хуруу үйлчилж байсан юм. Энэ үхсэн халим Ахабыг зовоож байх шиг санагдана, Моби Дик үхээгүй, хаа нэгтээ тэртээ алсад амьд байгааг санагдуулах мэт. Тэр аварга том бие манай онгоцыг тэр аяар нь дүүргэж, сэтгэл тун ч хөдөлсөн Стабб оройн хоолондоо халимын мах захиалж байсан юм.

Дараа өдөр нь бид халимаа янзлан жижиглэх нарийн ажлаа эхэллээ. Бараг нэг футын зузаан өөхлөг хайрс бүхий арьсыг хуулах нь жүрж хальсалж байгаа мэт санагдана. Эхлээд Старбак, Стабб хоёр урт гэгчийн хүрз ашигладаг билээ. Дараа нь аварга том дэгээгээр багийнхан ховхолж авсан хэсгийг өргөж, тосны өрөө рүү буулгана. Тэнд байгаа хүмүүс өөх тосыг нь ялгаж авахын тулд ороож эхэлнэ. Энэ мэтчилэн бүх тосыг ялгаж дуустал энэ үйлдэл дахин дахин давтагдах болой.

Нэг халимнаас бараг арван тонн орчим буюу зуун торх элбэг дүүрхүйц шингэн тос гарна.



Бидний ажил “Онгоцныхоон!” гэсэн дуугаар түр завсарлав. Энэ бол Нантукетээс яваа Жэрэбүм хэмээх халим агнуурын нэг онгоц байлаа. Тэднийг бидэн рүү чиглэн ирж, завиа буулгахад Старбак шатаа буулган, ахмадыг нь онгоцон дээрээ урих тушаал буулгав. Гэхдээ тэдний ахмад Мэхью Пекутын тавцан дээр гарахаас татгалзаж буй бололтой, гараараа



даллана. Бидэнтэй мэндлэхээр тэдний сэлүүрчид завиа манай онгоцны хажуугаар залан орж ирлээ. Жэрэбүмийнхэн яагаад манай онгоцонд зочлохоос татгалзсаны учрыг оллоо, тэдэнд аюулт тахал туссан аж.

Стабб нэг сэвхтэй нүүр, догшин байрын жижиг нүд, урт гэгчийн шар үстэй нэг сэлүүрчнийг танимхайрч, “Тэр Габриэль биш үү?” хэмээв. Багийн бусад гишүүдээсээ тэр сонирхолтой эр бол Шекер болон өссөн нэгэн гэнэ. Миний мэдэхээр Шекерүүд гэдэг нь биеэ сэгсэрч залбирал үйлддэг Америкийн нэг шашны бүлэг юм.

Жирийн нэгэн далайчин ч гэлээ тэр залуу өөрийгөө зөнч хэмээх тунхаглаж, Ариун Габриэль биеэрээ мөн тул онгоц толгойлно хэмээн шаарджээ. Ахмад түүнийг анх ирсэн далайн боомт руу нь хүргэгчхэнэ шүү хэмээн сүрдүүлэхэд Габриэль олон янзын бяцхан лонхтой зүйлсийг гарган задалж, хэрэв ахмад өөрийнх нь шаардлагыг биелүүлэхгүй бол багийнханд юу тохиолдож болох талаар аймшигтай сэрэмжлүүлэг хэлэв.

Өөртөө тун ч итгэлтэй, хачин хурц зантай залууг хараад багийнхан ахмад дээрээ очиж, хэрэв Габриэлийг онгоцноосоо хөөвөл нэг ч хүн амьд үлдэхгүй гэгцгээжээ.

Тэд түүнийг яагаад ч шийтгүүлэхгүй нь тодорхой болов. Тийнхүү Габриэль онгоцон дээр эрх чөлөөтэйгээ үлдсэн аж.

Жэрэбүм дээр тахал дэгдэх үед Габриэль улам хүчтэй болж ирлээ. Хэрэв өөрөө хүсвэл Габриэль өвчнийг зогсоож, мөн хүссэн үедээ дуудан авчирч чадах гэнэ. Далайчид түүний хэлсэн бүхэнд итгэцгээж байв.

Онгоцныхон цагаан халимын тухай сонсоод түүний араас баяр хөөртэй явцгаахад Габриэль мөн л хачин бүдүүлэг зангаараа аймшигт сэрэмжлүүлэг хэлэн, тэднийг зогсоожээ. Түүнийхээр бол Моби Дик нь халимын биед орчихсон Шекер бурхан юм байх.

Тэгсээр жилийн дараа тэд халимтай тааралдахад ахлагч Хэрри Мэкей түүний араас мөрдье гэжээ. Мэкей эцэст нь нэг хүний оронд таван хүн байхаар тооцож, завин дээр гаргав. Габриэль үхлийн ёр зөгнөж байсан ч мөнөөх эрчүүд далайн чөтгөрийн зүг илдээ далайжээ. Гэнэт уснаас цагаан сүүдэр гарч ирэн дээшилж, халим маш хурдтай дэвэх мэт хөдөлгөөн үзүүлэхэд сэлүүрчид амьсгалж ч чадахаа болиж хөшиж хоцорчээ. Дараа нь хөөрхий азгүй Мэкейн бие агаарт шидэгдэж, тэрээр унахдаа уртаас урт нуман хэлбэрийг үүсгэн далай руу бараг л тавин яардын тэртээгээс унажээ. Энэ зуур завинаас хэлтэрхий зомгол ч унаагүй, сэлүүрчдийнх нь толгойноос ширхэг үс ч хийсээгүй боловч шидэгдсэн нөхөр нь далайн ёроол руу үүрд живсэн ажгуу.

Энэ үүднээс ахмад Мехью манай эрхэм Ахабаас Моби Дикийг боломжтой бол устгах байсан эсэхийг асуув. Ахаб дуун дээр,

- Тэгэлгүй яахав хэмээн хариулсанд Габриэль хөл дээрээ үсрэн босч, тэр хөгшин эрийг цоо ширтлээ.

Тэгснээ эрхий хуруугаа гозойлгон уруу харуулж,

- Бурханыг доромжлогч Мэкейг бодоцгоо, тэр далайн гүн рүү үүрд орсон. Түүнтэй адилхан үхлээр үхэвзэй, болгоомжилцгоо! хэмээв.



Ахаб Нантукетээс авч гарсан, Жэрэбүм онгоцтой далайд уулзвал өгөх ёстой захидал бийг санан хажуу тийш эргэлээ. Старбак захидлыг авчрахаар яваад удалгүй чийг даан үнгэгдэж хуучирсан мөнөөх захидлыг авч ирлээ. Харанхуй чийглэг газар удсанаасаа болоод ногоон хөгцөөр хучигджээ. Старбак урт гэгчийн саваа модны үзүүрт хэрчлээс гарган захидлыг дамжуулах гэлээ. Түүнийг модны үзүүрт захидал хавчуулах зай гаргаж байх хооронд Ахаб тэр дугтуйтай бичгийг тайлж уншихыг оролдон,

- Ноён Хэрр... Тийм ээ, энэ эмэгтэй хүний бичиг бололтой, эхнэр нь байх шүү. Ноён Хэрри Мэкей, Жэрэбүм онгоц гэж байна. Энэ чинь Мэкейд ирсэн юм байна шүү дээ. Гэтэл тэр үхчихсэн байдаг...

- Наадахаа өөртөө хадгал. Чи ч бас удахгүй тэр замаар тонилно! хэмээн Габриэль Ахаб руу хашгирав.

- Хараал чамайг идээсэй! Үүнийг ахмад Мэхью хүлээн авна гэж Ахабыг хашгиртал Габриэль захидлыг булаан аваад хутгаа дүрж, буцаагаад Пекутын тавцан руу чулуудахад яг Ахабын хөлийн хажууд унав.

## Аравдугаар бүлэг

### Тавцан дээрх чөтгөр өө?

Төдөлгүй бид хэсэг энгийн халимуудтай таарлаа. Тэдгээр халимын тос нь спери халимынхыг бодвол бараг үнэгүй тул тэднийг агнаж төвөг удахгүй биз хэмээн таамагласан ч миний бодол талаар болж завинуудаа хурдан гэгч нь буулгаж эхлэв. Стабб, Пласк хоёр өндөрт оргилох цоргонууд руу уралдах мэт явлаа.

Стабб, Пласк хоёр нэг халимыг жадлан, хоёр завиараа түүнийг зогсоохыг хичээн үхээд чирэхэд бэлэн болох хүртэл биеийг нь сийчсээр л байлаа.

- Би тэр хөгшин эрийг ийм муухай бөөн бөөн үмхий өөхтэй зүйлийн юунд нь болдогт гайхдаг хэмээн Стабб хэлэв.

- Чи тэр сахиусных нь талаар урьд нь ямар нэгэн юм сонсоогүй гэж үү? Онгоц спери халимын толгойг онгоцныхоо баруун талдаа өргөөд, мөн жирийн халимыг зүүн хэсэгтээ байлгах аваас тэр онгоц хэзээ ч осолдохгүй гэлцдэг юм билээ.

- Та үүнийг хаанаас сонссон юм бэ?

- Педаллагаас. Тэр сүг сүүдэр шиг эр онгоцонд аймшигтай төгсгөл авч ирнэ. Түүний өнөөх ганц шүд үү! Яг л хорт могойн толгойг санагдуулам биш гэж үү, Стабб?

- Тэгэхээр үнэндээ би Педаллаг зүсээ хувилгасан чөтгөр гэж боддог. Бас бидэнд тэр чөтгөрийн сүүл нь эс харагддагийн учир гэвэл түүнийгээ хуйлаад халаасандаа хийчихдэгт л байгаа юм.

- Тийм ээ, бас тэр үргэлж л гуталтайгаа унтдаг биз, тийм ээ? - хэмээн Стабб үг нэмэв. - Тэр чөтгөрийн Педалла хэн нэг нь үзчихвэл мөрдөж мөшгөөд салахгүй биз гэж бодоод ямааных шиг золигийн туурайгаа тас нууж явдаг биз. Бас би түүнийг тэр хөгшин эртэй наймаалцана гэдэгт мөрийцсөн ч чадна. Хэрэв Педалла Моби Дикийг түүнд буулгаж өгөх юм бол хариуд нь ахмад сүнсээ өгөх болно.



- Чи тоглож байгаа байлгүй дээ, Стабб, Педалла яаж тэгж чадах билээ дээ?
- Мэдэхгүй юм, Пласк. Гэхдээ тэр чөтгөр тун хачин, хамаг ёр нь бүрдсэн нэгэн гэдгийг л би мэдэж байна. Маш анхааралтай байхгүй бол болохгүй шүү. За за, бид бараг ирчихлээ. Урагшаа сэлүүрдэж, халимаа онгоцон дээр гаргая. Тэгээд тэр хоёр завьтай ачаагаа Пекүд руу аажмаар ойртуулж ирэв.
- Стаб, чи ер нь Педаллаг хэдтэй гэж боддог вэ? хэмээн Пласкийг асуухад Стабб Пекүдийн хамгийн урт шураг өөд заан, хариулт өгөв.
- Чи тэнд байгаа шургийг харж байна уу? Түүгээр илэрхийлэх гэж оролдъё л доо. Түүнийг нэгийн тоо гээ, онгоцон дээр байгаа бүх торхны бүслүүрүүдийг араас нь тэг болгон тавья. Тэгвэл тэр тоо Педаллагийн насанд жаахан ч гэсэн дөхөж очиж магадгүй. Гэхдээ л ертөнц дээрх бүх торхны цагаригийг тэг болгон тавиад ч түүний насыг хэмжиж чадахгүй дээ.
- Гэхдээ Стабб, чи өмнө нь түүнийг ус руу чулуудахыг хүсэж байсан гээ биз дээ? Хэрэв тэр мөнх настай юм бол ингэлээ гээд үр дүнд хүрэх үү?
- Түүнийг ядахдаа нэг сайхан усанд шумбуулахгүй юу.
- Гэтэл тэр бас чамайг усанд шумбуулахыг хүсээд, чи түүнийг нь даалгүй живчихвэл яах вэ?
- Тийм өрөвдөлтэй оролдлого хийгээд үзээсэй, харах сан. Тэр чөтгөрийг чөтгөр аваасай...

Пласк, чи намайг түүнээс айдаг гэж бодоо юу? Хэрэв тэр хэл ам таталбал би түүний халаасан дахь сүүлийг нь шүүрэн авч, угз татан таслаад шившигт унагах болно.



- Тэр сүүлээр нь чи яах юм, Стабб?

- Түүгээр үү? Гэртээ хариад үхрийн ташуураар наймаалцан зарж орхино, өөр юу гэж?

Пласк толгой нь эргэсэн янзтай Стабб руу харснаа,

- Чи дөнгөж сая ярьсан эдгээр зүйл чинь тэгээд үнэн утгатай юм уу? гэлээ.

- За за, утгатай ч бай, утгагүй ч бай, бид онгоцон дээрээ ирлээ.

Онгоцны спери халим өлгөсний эсрэг талаас гинж доошлуулан унжуулж, энгийн халимыг өлгөн бэхлэхэд бэлэн болсон байлаа.

- Би чамд хэлээгүй билүү? гэж Пласк хэлээд Пекүдийн баруун талд өлгөсөн спери халимын толгой өөд заав. Тэгснээ, - Би чамд Педаллаг ингэнэ гэж хэлсэн шүү дээ. Энэ толгой удахгүй нөгөө талд нь өлгөгдөхийг харах болно хэмээв.

Тэр үед Пласкийн хэлсэн үнэн болж, халимын толгойг онгоцны ханан дээр өлгөв. Педалла түүнийг гардан хийх явцдаа ямар нарийн нягт судалж байгааг нь ч харсан билээ. Тэрээр толгойн дээрх үрчлээс болгоныг гарынхаа алган дээрх зураасуудтай харьцуулан, яг л ирээдүйг зөгнөсөн ямар нэгэн нууц захидал уншиж байх мэт харна.

Ахмад Ахабын зогсож байгаа байрлалаас болж, Педаллагийн сүүдэр түүний сүүдэрт бүхлээрээ багтсан байлаа. Хэрэв Педалла сүүдэртэй аваас энэ нь Ахабынхтай холилдон, нэг юм шиг болсон байв.

## Арван нэгдүгээр бүлэг


### Кюкег дахиад л гавьяа байгуулав

Пекүд спери халимынхаа толгойг нөгөө талдаа өлгөсний дараа маш чухал нэг ажилд орох хэрэгтэй болсон юм. Тэр бол эрдэнэс цуглуулах ажил байсныг хэлэх хэрэгтэй. Тэр эрдэнэс маань халимын дух орчимд байдаг асар том хүүдийтэй үнэт тос юм. Халимын толгойг огтолж буй хүн нь тэр уутыг нь цоолохгүйн тулд тун болгоомжтой хандах ёстой. Эс тэгвэл 500 галлон тос алга болно гэсэн үг.

Таштего халимын толгой руу буухын тулд онгоцноос ташуу байрлах гол бэхлэвч өөд авирлаа. Халимын толгой дээр буун буутлаа бэхлэвчнээс унахгүйн тулд тэрээр гараа тун авхаалжтай дээш өгсүүлэн барьж явав. Багийнхны нэг түүнд богинохон иртэй хүрз атгуулсан авч тэрээр шууд л ухаад эхэлсэнгүй, ханыг нь тогшиж, тун болгоомжтой үзэж байлаа.

Тэгээд яг зөв газрыг нь олсны дараа нэг төмөр хувинг худгаас ус авдаг ховоо шиг болгон олсныхоо нэг үзүүрт уяад нөгөө үзүүрийг нь тавцан дээрх хоёр хүнээр бариулав. Таштего саваагаараа хувинг далд ортол нь доошлуулах маягаар дарна. Дараа нь түүнийг дохио өгмөгц тавцан дээрх хоёр хүн олсноосоо татаж, дүүрэн хувинтайг дээш нь өргөн гаргаад асар том торхонд юулж, буцаан хоосон хувингаа түүнд өгч байв. Энэ маягаар индиан эр зуун удаа шаламгай хөдлөн, саваагаа бараг үзэгдэхгүй болтол гүн дарсны эцэст халимын духан руу бараг хорь орчим фүүт орсон байлаа. Гэнэт Таштего муухай дуу гарган хашгирснаа халимын духан дахь өнөө нүх рүү толгойгоороо унаад... үзэгдэхээ болилоо.

- Хүн уначихлаа! хэмээн Даггоо хашгираад өнөөх хувин руу хөлөө оруулан, доошоо буухыг хүсэв.



Гэвч төдөлгүй тас хийсэн огцом дуу гарч, хүн бүрийг зог тусан гайхашрахад хүргэлээ. Толгойг тогтоож байсан хоёр аварга том дэгээний нэг мултарч, толгой хажуу тийшээ савлаад нөгөө дэгээ нь бас гулзайж байгаа харагдлаа. Аянга мэт их нүргээн гарч өнөөх асар том зүйл далай руу оров. Дагтоо савлан буй олсоос зууран үлдсэн авч халимын толгой дотор амьдаараа булшлагдсан хөөрхий Таштего далайг ёроол руу живж эхлэх нь тэр.

Тэрхэн мөчид бид шураг дээр гартаа илд барьсан, тэнцвэрээ олж байгаа нүцгэн хүнийг харлаа. Дараагийн агшинд пүлхийх дуу гарч, миний эрэлхэг Кюкег хохирогчийг аврахаар ус руу орсныг бүх хүн мэдэв.

Хэсэг хугацааны дараа нэг гар яг л булшин дотроос гарч ирж байгаа юм шиг далайн мандал дээр гарч ирэхийг харлаа.

- Хоёулаа... тэд хоёулаа тэд байна гэж Дагтоо хашгирав.

Төд удалгүй зоригт Кюкег нэг гараараа индиан эрийн урт үснээс зууран, нөгөө гараараа сэлүүрдсээр гарч ирэв.

Сүүлд нь Кюкег хүн болгоныг нэгэн зэрэг гайхашруулсан тэр авралынхаа талаар ярьсан юм. Живж буй халимын толгойг гүйцэж очоод илднийхээ үзүүрийг таарсан газраа л дүрээд байж. Тэгээд Таштегогийн хөлийг олоод татаж гарчээ. Тэр бүхэн нь ихээхэн төвөгтэй байсан ч түүнийг аврах нь туйлаас чухлыг ойлгон хурдан гэгч нь бодон хөдлөөд хөлийг нь өөр лүүгээ огцом хүчтэй таган Индианы биеийг нь нугарахад татахад бэлтгэгдсэн гэдэгт найдан хөшиж түлхээд дараагийн оролдлогоор Таштегогийн үснээс зууран чирэхэд бүх зүйлс хүссэнээр нь



болсон байжээ.

## Арван хоёрдугаар бүлэг

### Цагаан халимын мөрөөр

Онгоцныхоон, цагаан халимыг харав уу? хэмээн өнгөрч байсан Английн далбаатай нэг онгоцноос Ахаб асуулаа.

Амандаа бүрээтэй нэгэн настай эр тавцан дээр зогсоно. Ахабын ясан хөл Самуэл Индербайн ахмадад нуух юмгүй харагдана. Ахмад биерхүү, наранд борлосон арьстай, жар орчим насны, сайхан зантай байрын нэгэн байлаа. Хүрэмнийх нь хоосон баруун ханцуй салхинд арагшаа хийсэх ажээ.

- Цагаан халимыг харцгаав уу? хэмээн Ахаб давтан асуув.

- Түүнийг харах ий? хэмээгээд ахмад спери халимын ясаар хийсэн ясан гараа үзүүлэхээр хүрэмнийхээ баруун ханцуйг шамлав. Гарынх нь үзүүр дэх модон толгой яг алх шиг харагдана.



Цөөн минутын дараа Ахабын завь нөгөө онгоцонд зочлохоор доошлов.

Хөгшин эрийг тавцан дээр очиход Индербайн ахмад урагшлан өнөөх ясан гараа түүн рүү урих маягтай сунгаж байна. Ахаб түүнтэй нь ясан хөлөө зөрүүлэн,

- Тэгэлгүй яахав, хоёул ясан гар хөлөөрөө мэндэлчихье, гарыг тань цагаан халим ингээ юү? гэлээ.

- Тийм ээ, - хэмээн ахмад хариулаад, - Бид жижиг завиа буулган, дөрөв таван халим агнаад байлаа. Нэгийг нь авинаасаа бэхлэхээр зэхэж байтал гэнэт далайгаас сүү шиг цагаан толгойтой аварга том бөгтөр халим цоройн гарч ирсэн...

- Энэ бол тэр! Моби Дик! хэмээн Ахаб хашгирав.

- Баруун талаар нь дүүрэн халим агнуурын жад эгнэсэн байлаа хэмээн ахмадыг нэмэхэд,

- Тэд чинь минийх! Миний жаднууд байгаа юм! Үргэлжлүүл, үргэлжлүүл! хэмээн Ахаб хашгирсаар.

- Тэр бэхлэгч олс руу маань довглон хазаж эхэлсэн.

- Тийм ээ, тэр суллагахыг л хүсэж байгаа нь тэр. Энэ түүний хуучин аргуудын нэг, би түүнийг мэдэлгүй яахав.

- Олс түүний шүдэнд орж, бид олсоо татахад манай завь түүний бөгтөр нуруу өөд гулсан гарлаа. Тэр үнэхээр миний бүхий л амьдралдаа харсан хамгийн сүртэй, хамгийн том халим байсан. Түүний догшрон хилгэнэсэн байгааг ч үл хайхран, бид түүнийг олзлохоор зориглов. Би завь руугаа үсрээд хамгийн ойр байсан нэг жадыг шүүрэн авч, өнөө халим руу шидлээ.

Ахаб түүний ярихыг амьсгаа даран сонсоно.

- Дараа нь миний олж харсан зүйл гэвэл усан дотроос яг л гантиган цамхаг мэт эгцрэн гарч ирсэн халимын сүүл агаад хар хөөсөн дунд тэр сүүлнээс өөр юуг ч харагдахгүй байсан юм. Гэнэт тэр сүүл доошилж завийг нь хоёр хуваагаад завины үлдэгдэл сэг дундуур цааш эргэхийг нь анзаарсан.

- Дараа нь юу болсон бэ? хэмээн их л хүлээцтэй сонсож байсан Ахаб асуув.

- Би түүн дээр зоогдсон жаднаасаа шүүрэн авлаа. Хэдэн хормын турш би түүнээс зууран явсан хэдий ч далай намайг түлхэн унагааж, тэр халим нүд ирмэхийн зуур доошлоод явчихав. Гэвч ингэх зуур хоёр дахь муу ёрын төмрийн үзүүр миний мөрөнд нэвт зоогдож, тэр намайг тамын дөл рүү чирэн орж байна гэж би бодсон юм.

Ахаб үүнийг сонсоод ахмадын ясан гар тэндээс эхэлж байгаа мөрнийх нь доогуур харлаа.

- Сайн Бурханы ачаар амьд гарсан шүү. Тэр жадны үзүүр гарыг минь тэр чигээр нь цуулан зүсэж, бугуйны орчимд ирэхдээ суларч, тэр үед намайг усны гадарга дээр гаргаж ирлээ хэмээн ахмад яриагаа үргэлжлүүлнэ.



Онгоцны эмч ярианд оролцож,

- Тийм шүү, бараг хоёр футийн урт шарх байсан. Дараа нь улам сэдэрч хүндрээд гарыг нь тайрч авахаас өөр ямар ч аргагүй болсон гэлээ.

- Цагаан халим юу болсон бэ? гэж Ахаб асуув.

Түүний сонирхлыг татаж байсан цорын ганц зүйл энэ байсан юм.

- Бид түүнийг ахин хоёр удаа харсан.

- Чи тэгээд түүнтэй ахин тулалдаагүй хэрэг үү?

- Дахиж оролдох хүсэл байгаагүй юм. Нэг мөчөө алдсан минь надад хангалттай биш гэж үү? - гэж англи ахмад хэлээд Ахабын ясан мөч рүү хяламхийн харж, - Тэр халимыг зүгээр л зөнгөөр нь орхичих хамгийн сайн арга гэдэгтэй та санал нийлэхгүй байна уу? гэхэд,

- Магадгүй л юм, гэхдээ л би түүнийг мөрдөн мөшгөхгүй байж чадахгүй. Тэр аль зүг рүү чиглээ бол? хэмээн хатуу чанд өнгөөр асуулаа.

- Миний бодлоор... тэр зүүн зүг рүү явсан байх, - гэж хэлээд Педалла руу эргэж, - Бурхан минь, ахмад Ахаб галзуу юм уу? хэмээн шивэгнэв.

Педалла уруул дээрээ хуруугаараа чагт тавиад сэлүүрээ авахаар Самуэл Индербайн шонгийн

дэргэдүүр гулсан өнгөрсөн юм.

Удалгүй Ахаб завиа сэлүүрдэхээр завдан буй эрчүүдийнхээ дунд орж зогслоо. Англи ахмад түүнийг дуудахаар дэмий л оролдсон авч Ахаб Пекутын хажууд очих хүртлээ нуруугаа Индербай руу харуулан, хөшөө мэт хөдөлгөөнгүй явжээ.

## Арван гуравдугаар бүлэг

### Амьдралд эргэж ирэв

Ингэхэд бид үнэт ачаа болох халимын тостой олон торхнуудаа авч явсан гэдгийг хэлэх хэрэгтэй. Тавцан доорхи агуулахад тэдгээрийг хадгалдаг агаад найдвартай хамгаалахын тулд эрчүүд маань долоо хоногт хоёр удаа тогтмол далайн усаар шүршдэг байв. Энэ нь хоёр зорилготой. Нэгдүгээрт, ус модон торхнуудыг хөөлгөн нягтруулж, бөх бат болгоно. Хоёрдугаарт, далайчид тийнхүү шүршсэн усаараа торхноос тос гоожиж байгаа эсэхийг шалгадаг байсан аж. Ингэснээрээ тэд торхнуудад нүх цоорхой гарсан эсэхийг ч шалгах боломжтой.



Бид Индербайтай уулзсаны маргааш өглөө далайчид маань торх руугаа усаар шүршиж байгаад их хэмжээний тос устай холилдож гарч ирэхийг харжээ. Старбак үүнийг шалавхан мэдэгдэхээр Ахабын өрөө рүү үсрэн орлоо.

- Агуулахад тос гоожиж байна эрхэм ээ, бид торхнуудаа байрнаас нь хөдөлгөж цоорхой хаана байгааг харах хэрэгтэй болоод байна.

Энэ үед газрын зураг дээрээ хичээнгүйлэн ажиллаж байсан Ахаб уурлан өндийж,

- Бид Японд хэтэрхий ойртож ирээд байна. Хуучин торхнуудтай ноцолдон дэмий үрж байх цаг зав алга...

- Гэхдээ эрхэм ээ, - гэж Старбак үгийг нь таслаад, - Бидний нэг жилд хуримтлууулж чадахаас илүү их тос нэг өдөрт сүйдчих гээд байна. Бид эх газраасаа гараад 20000 бээр хөвж явна. Цалингаа юугаараа авах билээ? гэлээ.

- Хэрэв бид үүнийг зорьж ирсэн бол таны зөв өө. Гэхдээ...

- Би танд ачаатай байгаа тосны талаар ярьж байна гэж Старбак тайвнаар өгүүлэв.

- Харин би бол үгүй. Урсаж л байг, одоо явж үз, Старбак минь хэмээн Ахаб хашгирлаа.

- Гэхдээ эрхэм ээ, эзэмшигчид юу гэх болж байна?

- Тэднийг далайн шуурганаас ангид Нантукетийн эрэг дээр аваачаад орхичихгүй юу. Ахабад энэ ер ямар ч хамаагүй. Аливаа зүйлийн цорын ганц жинхэнэ эзэмшигч бол удирдагч нь байдаг юм шүү дээ. Ахаб бол Пекүдийн удирдагч. Яг одоо тавцан руугаа буц.

- Гэхдээ ахмад аа...

- Энэ дэлхийг тэр аяар нь эзэгнэгч цорын ганц бурхан байдаг шиг Пекүдийн захирагч нэг л байдаг юм. Тавцан руугаа арилж үз! хэмээн өлгөөтэй буугаа ахмад шүүрэн авахад Старбакийн нүд нь гялалзаж, хацар нь улайх шиг болсноо удалгүй өөрийгөө тайвшруулж чадав бололтой, ахмадын өрөөг орхин гарснаа, үүдэн дээр очоод эргэн харж,

- Та намайг доромжлоогүй ч ихээхэн бухимдууллаа. Цаашид Старбакаас болгоомжил гэж би танд сануулахгүй. Та зөвхөн шоолон инээх л биз. Гэхдээ эрхэм ээ, танд гэж хэлэхэд Ахабаас болгоомжилж яваарай. Таны хамгийн аймшигтай дайсан тань та өөрөө юм шүү гэлээ.

Старбакийг явсны дараа Ахаб “Ахабаас болгоомжил, Ахабаас болгоомжил” гэсэн үгийг яагаад ч юм дотроо шивнэсээр байсан юм.

Эцэст нь Ахаб яагаад Старбакийн үгийг дагахаар шийдсэнийг нь таамаглахад хэцүү юм. Энэ нь хэсэг зуур ч болов үнэнч байх гэснийх үү, эсвэл өөрийн итгэлт офицертэй сайн харилцаагаа хэвээр хадгалах гэснийх үү, мэдэхгүй. Тэрээр халимын тостой торхнуудыг шалган, эмх цэгцтэй гэгч тавих шийдвэр гаргажээ. Тэр их шавар шавхай, чийг болсон газарт аварга том торхнуудыг нааш цааш зөөсөн хүнд хэцүү ажлаас болоод хөөрхий Кюкег чийг бамын өвчинд баригдаж, өндөр халуурч эхлэлээ. Маш их турж, цонхийсон түүний дүүрэн шивээстэй бие тун давжаа харагдаж өдрийг дүүжин орон дээрээ л өнгөрөөдөг болов. Нэг өдөр Кюкег их сонин зүйл асуусан юм. Тэрээр Нантукетэд байхдаа яг л өөрийнх нь уугуул нутгийн арал дээр байдаг шиг хар модоор хийсэн бяцхан тагтай завийг харж л дээ. Түүний хэлснээр бол Нантукетын нас эцэслэсэн бүх халим агнагчдыг тэдгээр хар завинуудад оршуулдаг байж. Тэр нь түүнд ихээхэн таалагджээ. Учир нь тэдний нутгийн ёс заншилд ч мөн адил, зоригт дайчдаа насан эцэс болоход нь тийм завинд хэвгүүлж од түгсэн шөнөөр хөвүүлдэг ажээ.

Онгоцны мужаанд тэрээр өнөөх хүслээ хэлсэнд мужаан хүрэлцэн ирээд Кюкегийг тун нямбай хэмжлээ. Пекут дээр бүр эртнээс л хадгалагдсан, бараг л бүх аяллын турш цуг байсан

Хөгжмийн хар моднуудыг ашиглан сайхь мужаан авсан завь хийж эхлэв.



Ажлын дараа Кюкег жадаа авсандаа хүндэтгэлтэй байрлуулж, мөн сэлүүрээ ч хамт хийлээ. Бас цэвэр устай дашмаг, модон цүнхээ, далайчны хувцсаа хүртэл дэр болгон тавихыг гуйв. Энэ бүгдийн эцэст тэрээр сүүлчийн орондоо гараа зөрүүлэн хэвтээд өөрийнхөө Ёжо хэмээх бяцхан сахиусаа цээжиндээ авлаа. Дараа нь тэр дүүжин орондоо буцан хэвтэх дохио өгөв.

Үхэлдээ ийнхүү яг таг бэлдэж, авс нь түүнд онцгой сайхан таарч байсан ч гэлээ гэнэтхэн дээрдэж, үхэх бодол нь ч өөрчлөгдсөн юм. Одоо тэрээр бэлдүүлж авсан авсаа далайчны авдар болгон хэрэглэж, зотон даавуун хувцсаа хийн хадгалах болов. Тэгээд болоогүй өдрийн ихэнхийг авсан дээрээ янз бүрийн сонин дүрс, зураг сийлэн өнгөрөөдөг болсон. Тэдгээрийн ихэнх бие дээрх орооцолдон мушгирах шивээсийнх нь хуулбар байсан юм. Энэ шивээснүүд нь нэгэн зөнч хүн дэлхий болон дээд тэнгэр, тэдгээрийн төгс төгөлдөр уялдаа холбоог хэрхэн тайлж зөгнөсөн тухай ажээ. Кюкег үнэхээр амьд оньсого шиг хүн байсан сан. Нэгэн боть нууцлаг түүх ч гэж хэлж болохоор авай.



# Арван дөрөвдүгээр бүлэг

## Ер бусын таамаглал

Пекут тавцан дээрээ Перт хэмээх төмрийн дархантай. Ахаб түүнийг нэгэн онцгой зүйл хийж чадахыг нь харах гэж ууттай хадаас, уралдааны морьдын тах тэргүүтнийг авч ирээд тэднийг хайлан асар хүчтэй жад хийж чадах эсэхийг асуув. Перт хурц шовгор халуун үзүүр бүхий дэгээ, мөн хүйтэн устай торх авч ирэхийг хүслээ. Хүйтэн ус нь төмрийн уян хатныг тэнцвэржүүлж бат бэх болгоход хэрэгтэй аж. Гэвч Ахаб өөр бодолтой байсан тул,

- Үгүй ээ, үүнийг хийхэд ус хэрэггүй. Би жадны үзүүрийг жинхэнэ үхлийн зэвсэг болгох сон хэмээн хүсэж байна. Энэ төмөр цусанд л хатах ёстой, - гээд гурван индиан руугаа эргэн, - Таштего, Даггоо, Кюкег та нар энэ зэвсгийн үзүүрийг хатаах цус өгч чадах уу? гэхэд тэр гурав зөвшөөрч, арьсаа зүсэцгээн цусаа өгөхөд бэлэн болов.



Удалгүй өнөөх цагаан халимыг зүйл дуусгахаар давгагдсан жадны үзүүр хүний цусанд.. хатан бэхжлээ.

Шөнө нь Ахаб хар дарсан зүүдлээд сэргэж ирлээ. Тавцан руу гарахад Педалла манаанд гарч байна. Ахаб түүнд өөрийнхөө хэрхэн үхсэнийг, мөн хөдөөлүүлэх тэргээ харж байгаа мэтээр зүүдэлснээ ярихад Педалла түүн рүү дэнлүүнийхээ сүүмэлзсэн хурц гэрлийг тусган харснаа,

- Би танд үхэл рүүгээ очих тэр замыг тань хэлсэн шүү дээ, санахгүй байна гэж үү? Танд авс болоод хөдөөлүүлэх тэрэгний аль нь ч хүртээлгүй гэлээ.

- Тиймээ санаж байна, санаа ч зовж байна. Далай дээр насан эцэслэсэн хүмүүст шарилын тэрэг хэрэггүй гэдэг нь ойлгомжтой.

- Тэгэлгүй яахав, би танд үхэхийнхээ өмнө хоёр шарилын тэрэг харна гэж хэлсэн дээ. Эхнийх нь хүний гараар бүтээгдээгүй, харин хоёр дахь нь Америк модоор хийгдсэн байх ёстой гэж Педалла хэлэв.

- Тэр ч далай дээрх үнэхээр ер бусын зүйл байх нь гарцаагүй, - гэж Ахаб хүлээн зөвшөөрлөө.  
- Гэхдээ чи өөрийнхөө тухай ямар нэгэн юм хэлээч?

- Түүний тухайд бол би таны өмнө явна аа. Таныг нөгөө ертөнц рүү хөтлөх л гэж тэр шүү дээ.

- Тэгэхээр, Педалла, чи үхсэнийхээ дараа надад газарчлахын тулд дахин ирнэ, тийм үү? Тэр хүртэл би харин Моби Дикийг үгүй хийж, мөн энэ түүхээ ярихын тулд амьд явна.

- Энд бас нэг зүйлийг нэмж хэлэхэд таныг зөвхөн олс л үгүй хийж чадна гэж зөнч индиан хэлжээ.

- Чи дүүжлүүрийн талаар ярьж байна уу? Тийм юм хэзээ ч болохгүй, - хэмээн Ахаб доогтой инээгээд, - Тиймээс би мөнх амьдарна гэлээ.

Бид Ахабын Моби Дикийг олох горьдлоготой байгаа Экваторын ойролцоо ирлээ. Тэндээс бид уйлаад байгаа юм шиг хачин чимээ олж сонсов. Сүнснүүдийн орилоо л ийм байдаг байх. Тэр муухай уйлаан бидний ойролцоох нэгэн хадат арлын тэндээс сонстоно. Багийн юм мэддэг байрын хэдэн гишүүд маань тэднийг лусын дагина гэж үзэж байсан агаад дотор нь эвгүйрхэж, нилээд жихүүцсэн шинжтэй харагдана. Харин бөөгийн шашинтай дайчид маань төвийг сахиж байсан юм. Английн нэгэн эрэгт орших Эр хүний арал гэх хачин нэртэй газраас ирсэн хөгшин далайчин маань огт өөр бодолтой байлаа. Хөгшин Максманыхаар бол бид саяхан далайд живсэн эрчүүдийн дууг сонсоод байгаа ажээ.

Удалгүй Пласк Ахабт тэр жихүүдэс хүрэм дууны тухай хэлэхэд ахмад биднийг шоолон инээснээ,



- Би эндхийн бүх арлыг арван хуруу шигээ мэднэ ээ. Энэ бол зулзагаа алдсан эх хав болон эхээ алдсан зулзган хавнуудын уйлаан гэсэнд тэр тайлбар нь багийнханд зөвхөн муу мэдрэмж л төрүүлэв.

Ихэнх далайчид далайн хавны тухай мухар сүсэгт итгэдэг юм. Тэр нь бодит үнэн байгаагүй ч хавнуудын хүнийхтэй төстэй зовлонт дуу хоолой, ухаалаг гэмээр төрх нь бидэнд нэг л онцгүй ёр төрүүлж, эрчүүд маань ямар нэгэн муу зүйл тохиох нь гэсэн таамаглалтай үлдэв.

Мэдээж муу зүйл болсон нь цагаан халим харуулдахаар гол шураг дээр харуулд гарч байсан нэг нөхөр маань нойрмоглож байгаад далай руу унаж орхив. Даруйхан гэгч нь бид түүнийг аврахаар аврах завиа онгоцныхоо хажуу руу чулуудсан юм. Харамсалтай нь наранд хэт удаан хадгалагдаж, хагсаж агшсан завь маань дээрээсээ дарсан хүнд жингээсээ болоод золгүй далайчинтайгаа бүр мөсөн хэмхэрч одлоо.

Одоо л эрчүүд маань тэр хавнууд ямар ёр зөгнөн гонгинолдоод байсныг мэдрэх шиг болов. Харин хөгшин Максман л тэдний зөв гэдгийг хүлээн зөвшөөрсөнгүй.

Бид дараа нь хэрэглэхээ бодон аврах завиа шинэчлэх хэрэгтэй болсон ч түүнийг хийх хангалттай хөнгөн, зөөлөн модон торхнууд олно гэдэг амаргүй байлаа.

Кюкег өнөөх авс руугаа зааж, “Энэ боломжийн юм биш үү?” хэмээн санал болгоод бага зэрэг хатуу модоор шинэчлэх нь зүйтэй гэв. Тэр санал анхандаа удирдагчдад хачирхалтай санагдаж

байсан ч эцэст нь мужаан тагийг нь бөхлөн хадаад ус нэвтрүүлэхгүйн тулд сайтар чигжих хэрэгтэй гэсэн тушаал хүлээж авав. Ингээд авс Пекутын аврах завь боллоо.

Маргааш нь бидний өмнөөс эрчүүд нь тавцан дээрээ бөөгнөрөн зогсох Речил хэмээх томоос том онгоц айсуй.

- Цагаан халим хараагүй биз? гэх өнөө л асуултаа Ахаб давтана.

- Тийм ээ, өчигдөр харсан шүү. Харин та нар халим агнуурын сул завь харав уу? гэх хариу Речилээс сонсогдов.

Моби Дик үзэгдсэн гэх баярт мэдээг сонсоод Ахаб өнөөх асуултад нь ч хариулалгүй Речилээс илүү их мэдээлэл авахсан гэхээс элдэв янзын юм шалгааж гарав.

Речилийн ахмад Ахабын сонсохыг тэсч ядан хүлээх тэр асуултад нь хариу болгон,

- Бидний дөрвөн завь цагаан сэрвээтэй халимын араас хөөцөлдсөн юм. Манай хамгийн шилдэг завь араас нь бэхлэгдчихсэн юм шиг түүнийг шил даран хөөж явлаа. Удалгүй урд явсан хоёр завь маань халимын хамт үзэгдэхээ больж, ор сураггүй алга боллоо. Шархтай халим хоёр завьтай анчдыг маань чирээд явчихлаа гэж бодоод бид шөнөжин хайгаад ч завины хэлтэрхий олж харсангүй хэмээн өгүүлэв.

Ахаб ихэд гонсойсон шинжтэй харагдаж байсан ч ахмад үргэлжлүүлэн,

- Танаас бидэнтэй нэгдэн, хайгуулд маань оролцох эсэхийг асуухаар энд ирсэн юм. Бид яг энэ хавиар зэрэгцээ шугамыг дагуу самнан эрчүүдээ хайх болно. Бас... - гээд хэсэг зуур түгдэрснээ - Миний хүү тэнд яваа юм л даа гэлээ.

Речилийн ахмад, Ахабын хүйтэн царайг ажигласан бололтой,



- Бурханыг бодоод эрхэм ээ, би танаас гуйж байна, надад онгоцоо түр хөлслүүлээч. Би танд баяртайгаар хөлсөө төлөх болно хэмээхэд

- Бид тэр хүүг аврах ёстой! гэж Стабб тэндээс хашгирав.

Стабб үүнийг тавцан дээрх бүх хүн сонсоосой, тэдгээр гунигт эрчүүдээс талархлын үг сонсохсон гэхдээ хэлсэн гэдэгт би итгэлтэй байна. Яг тэр мөчид хөгшин Максман чимээгүй олны дундаас гараа өргөн,

- Тэр хүү өнгөрсөн шөнө бусадтайгаа хамт живчихсээн, бид тэдний сүнсний дууг сонсоогүй гэж үү? гэлээ.

Ахаб Речилийн хэрэг явдлыг үл тоомсорлож байгаа нь илт, ахмад руу хандан тун ч тайван хүйтэн царайгаар,

- Бид үүнийг хийхгүй. Яг одоо цагаа хий дэмий үрмээргүй байна. Баяртай, бурхан таныг ивээг, эрхэм ээ! гэжээ.

Речилийн ахмад хэсэг зуур юу хэлэхээ мэдэхгүй, мэгдэн зогсоно.

Ахаб өөрийн туслах Старбакдаа хандан гурван минутын дотор эдгээр хүмүүсийг онгоцонд нь хүргэчихээд далбаагаа дэлгэ гэлээ.



## Арван тавдугаар бүлэг.

### Эхний өдрийн ангуучлал

Цөөн өдрийн дараа бид Дилайт гэх тааруухан нэртэй өөр нэгэн онгоцтой таарлаа. Ахаб өнөөх л чухал хэдэн асуултаа тавихад ахмад нь үг дуугүй онгоцон дээрх сэг болсон завь руугаа заав.

- Түүнийг алаа юу?

- Жад маань хараахан түүнийг гүйцээхэд бэлэн биш бололтой.

- Би яг энд түүний үхлийг гүйцээх болно гэж Ахаб хашгирлаа.

- Бурхан танд тусална эрхэм ээ, би тэр хараал идсэн цагаан халимаас болж таван сайхан эрээ алдчихлаа. Та тэдний булшин дээр хөвж явна гэлээ.

Тэдэнтэй зөрөн өнгөрсний дараа Старбак хараал идсэн цагаан халимын бузар ангуучлалдаа бууж өгөх талаар ахин дахин ухуулсаар л байв. Тэгээд Ахаб руу эргэн, царайчлангуй харж,

- Бид ачаатай яваа шүү дээ! Яагаад хөөрхий энэ эрчүүдээ эхнэр хүүхдүүдэд нь эсэн мэнд аваачаад өгчихөж болдоггүй юм бэ? гэлээ.

Тэр үед Ахаб хачин зөөлөн харагдаж байсан агаад уртаар санаа алдаад эхнэр хүүхдүүдийнхээ тухай ярьж эхлэв.

- Миний хүү одоо алхаж байгаа, орон дээрээ өндийн суугаад ээжээсээ намайг далайд хэрхэн аялж яваа тухай сонсдог гэсэн. Гэвч одоо би яаж түүндээ буцан очиж, хамтдаа тоглох юм бэ?

Ахаб хэсэг зогсноод,



- Намайг үргэлж хэрэгцээгүй зүйл хийлгэж, болчимгүй юм руу түлхэж байдаг нэг мангас байдаг юм. Үгүй ээ, Старбак, чөтгөрийн Моби Дикийг устгахаас нааш хэзээ ч сэтгэл минь амрахгүй нь гэж нэмж хэлэв.

Шинэ өдөр ирлээ. Ахаб далайн агаарыг шиншлэх мэт байснаа “Халим ойрхон байна” гэж зарлалаа. Удалгүй бид спери халимнаас ялгардаг өнөөх өвөрмөц үнэрийг мэдэрцгээн, хөгшин эр маань хөлөг онгоцныхоо чиглэлийг түргэн өөрчлөв. Ахаб,

- Би тэр халим руу дайрах анхны хүн шүү! Ахаб, ганцаараа, ганцаараа! гэж хашгираад дээр үед хадаж байсан алтан зоос руугаа заалаа.

Ахаб өөртөө олсоор боломжийн сагс сүлжиж аваад, дотор нь орон суух үед хоёр хүн олсноос татан, далайг тэр чигээр нь харж чадахуйц өндөрт түүнийг гаргав. Бусад харуулуудаас бараг хоёр, гурав дахин өндөрт байсан тэрээр гэнэт “Тэр байна, тэнд оргилуураа үлээж байна, яг л цаст оргил шиг нуруутай Моби Дик мөн байна!” гэж далайн цахлай шиг дээрээс чарлана.

Тавцан дээрх эрчүүд энэ урт удаан хугацааны дараа тэр алдарт халимыг харахаар онгоцон дээрээ үймж эхлэв. Моби Дик ганц бээрээс хэтрэхгүй зайд байх нь тэр. Далайн давлагаа түүний өндөрт гялалзах нуруу болон агаарт үзэгдэх цоргыг нь огтхон ч хааж үл чадна.

- Та нар түүнийг өмнө нь харж байсан уу? гэж Ахаб тэртээ дээрээс эрчүүд рүү бас орилов.

- Харсаан, гэхдээ агшин зуурт л байх гэж Таштего хэллээ.



- Агшин зуурын төдийг тооцохгүй, - гэж Ахаб хэлэв. - Үгүй ээ, тэр алт бол минийх, хувь тавилан үүнийг ганцхан надад л хадгалсан. Бас би л түүнийг үгүй хийж чадна.

Ахаб сэтгэл нь хөөрч догдолсон хүмүүстээ хандан

- Бэлэн байцгаа! Бэлэн байцгаа! Ноён Старбак, намайг доош нь буулгаач! Хурдал, хурдал, завинуудаа бэлэн болгоцгоо! хэмээн хашгичсаар тавцан руу гулсан буулаа.

Хамгийн түрүүн Старбак тулалдахаар завиа буулгаж, араас нь бүх завинууд буув. Ахаб цагаан халимын толгойн үрчлээс, түүний орчимд зүггүйхэн бүжих тод өнгөтэй хөөснүүдийг харжээ. Цагаан халимын нуруун дээр халим ангуучдын хэзээ зоосон нь үл мэдэгдэх хагарч эвдэрсэн жаднууд үзэгдэнэ. Тэр туйлын тайван, тогтуун харагдаж байсан юм, учир нь тэр аймшигт шүднүүдээ усан доогуур нуусан байлаа.

Гэнэт халим дээшилж, аварга том биеэ том цагаан нуман хэлбэртэй болгосноо сүүлээ сануулга өгч байгаа юм шиг хөдөлгөв. Тэгээд сүүл нь өөрийнхөө үүсгэсэн том гэгчийн усан эргүүлэг рүү эргэн дүрэгдлээ.

Гурван завь Моби Дикийн эргэн ирэхийг нь отон, нам зогсоцгооно. Ахаб завин дээгүүрээ тонгойж, далайн гүнийг ажиглах мэт харав. Нэгэн цагаан юм маш хурдан дээшлэх нь үзэгдэж, хоёр эгнээ аймшигт шүд харагдлаа. Энэ бол Моби Дикийн эвшээж буй ам байсан юм. Ахабын завин дор ангайн буй тэр ам яг л гантиган бунхан мэт харагдах авай.

Ахаб залуураа хөдөлгөн, завиа аймшигт догшин халимын амнаас холдуулсан юм. Ингээд Моби Дикийн маш том, нуман бөөрөнхий нүүр гарч ирлээ. Муу ёрын ухаан нь дээд зэргээр хөгжчихсөн чөтгөр маань төлөвлөгөөг бүгдийг ойлгосон бололтой. Моби Дик зальтай гэгч нь толгойгоо бөхийлгөөд завийг тас хийтэл мөргөв. Урт нарийхан эрүүгээ нээн, амаа нуман хэлбэртэй болгоход нэг шүд нь сэлүүрийн нүхэнд ороод гацчихлаа. Цагаан халимын эрүү, Ахабын толгой хоёрын хооронд ердөө л зургаан инчийн зай байлаа. Ахабыг ойртоход тэр яг л муур идэх гэж буй хулганаа амандаа сэгсэрдэг шиг завийг нь зөөлөн займчиж эхлэв.

Багийн бусад гишүүд халимын ангайсан амнаас аль болох холдохыг хичээн, завины хойд хитэг рүү очихын тулд нэг нэгэн дээрээ бүдчиж унаж байхад Педалла л гараа зөрүүлэн огт хөдөлгөөнгүй сууна.



Ахаб дайсантайгаа ийм ойр байвч юу ч хийж чадахгүйдээ галзуурах шахаж байв. Завинаас зуурсан түүний шүдийг мултлах гэж нүцгэн гараараа эрүүнийх нь яснаас зуураад ч нэмэр болсонгүй. Түүний эрүү Ахабын гараас мултран доошоо гулссаар аварга том хайч мэт хөөрхий завийг бүхэлд нь хоёр хувааж орхилоо. Моби Дик ийнхүү догшрон эргэлдэхэд эрчүүд ус руу цацагдав. Тэр ахин аймшигт дайралт хийх гэж байгаа юм шиг усан дээгүүр хөөс цахруулан эргэлдэнэ.

Бусад завинууд ойр орчимд байжээ. Тэд бүрэн бүтэн байсан ч Ахаб болон усанд унасан бусад руугаа очихыг хүссэнгүй, учир нь тэд халимын дайралтаас айж байсан юм. Аз болоход Пекут халим болон сэлж яваа эрчүүдийн дундуур орж ирлээ. Моби Дик цаашаа сэлэн одоход бусад далайчид туслахаар ирэв.

Далайн дунд нэг хэсэгтээ л хөшчихөөд байсан Ахабыг Стаббын завь руу чирэн оруулахад тэр хөл дээрээ босож,

- Надаас гараа холдуул. Цус дахин судсаар минь гүйж эхэллээ. Далбаагаа тохируул, эрчүүд ээ! Сэлүүр дээр очицгоо, халимын араас! хэмээн гараа сарвайлаа.

Гэвч аврагдсан хүмүүс нэмж сэлүүрдээд ч завь маань сүр хүчээ үзүүлсэн цагаан халимыг бараадаж очсонгүй. Моби Дик цаашаа улам хурдлан алга болов.

Эцэст нь бүгд Пекутын тавцан дээр гарч ирэхэд Ахаб ахиад л өнөөх зоосныхоо тухай ярилаа.

- Энэ алт бол минийх, би үүнийг өөрийнхөө хүч чармайлтаар олж авсан юм шүү. Гэхдээ цагаан халимыг үхтэл энд хадгална. Түүнийг үхэх өдөр нь түрүүлж харсан хүн энэ зоосыг авах болно. Хэрэв тэр өдөр би дахиад Моби Дикийг харвал энэ алтнаас арав дахин үнэтэй зүйлийг та бүхэнд хувааж өгөх болно. Одоо тарцгаа.

Тэрээр ингэж яриад, зогсож байсан газраасаа алхам ч холдолгүйгээр үүр цайтал тэндээ байхдаа магадгүй, босоогоороо нүдний хор гаргасан биз ээ.

Моби Дикийг үгүй хийх эхний өдрийн ангуучлал ийнхүү төгслөө.

## Арван зургадугаар бүлэг

### Хоёр дахь өдрийн ангуучлал

Маргааш нь гол шургийн орой дээрээс “Тэр тэнд явна, тэр тэнд явна. Өнөө халимын чинь оргилуур яг тэнд байна. Яг тэнд” гэх танил үгс сонсогдлоо.

- Тэгэлгүй яахав, би мэдэж байсан юм. Чи одоо мултарч чадахгүй дээ. Шүдээ ярзайлган ус оргилуулах золигийн халим минь, муу ёрын галзуу чөтгөр өөрөө чиний араас явж байгаа шүү. Ахаб чиний цусыг боох болно, яг л тариачин сувгийнхаа усыг хаадаг шиг хэмээн Стабб хашгирлаа.

Тэр их сэтгэлийн хөөрөл нь багийн бүх гишүүдийг хормын дотор эзэмдэн авч, өмнө нь мэдэрч байсан муу ёр, айдас нь ор сураггүй алга болов. Тэр гучин хүн ахмадынхаа эцсийн зорилго руу яг л нэг хүн шиг шамдан орлоо. Ахаб өөрийнхөө өндөр суудал руу орж суув. Тэнд буй хүчирхэг гучин хоолойноос нэгэн ялалтын уухай цуурайтахыг тэр бараг л сонсоогүй байжээ.



Нэг бээрээс холгүй газар Моби Дик бидэнд харагдав. Өмнө харсан шиг тайван, залхуутай байдлаар биш, харин илүү сонирхолтойгоор бүх биеэ агаарт шидэн байна. Энэ нь өөрийгөө хамгаалах нэгэн төрлийн үйлдэл гэлтэй. Ахаб,

- Тэр үсэрч байна. Чиний наранд үсрэх сүүлчийн боломж доо, Моби Дик минь. Чиний амьд

явах хугацаа дууссан! Миний жад бэлэн байна, эрчүүд ээ, завиндаа! хэмээн хашгирав.

Ахаб тавцан руу бууж, яаравчлан завиндаа суулаа.

Моби Дик өрсөлдөгчдөө айлгахын тулд анхныхаа дайралтыг хийж, гурван завь руу зэрэг чиглэн хурдаллаа. Тэр үед Ахаб цагаан халимын толгойг чиглэн тэргүүлж явав. Яагаад гэвэл тэр хэрцгий амьтан урд талаасаа илүү хоёр хажуу талаа сайн хардаг юмсанж. Завьчид гэвч түүний дэргэд очихоос өмнө гурван завийг гурвууланг нь онилсон Моби Дик амаа ангайлган, сүүлээ шавхуурдсаар дайран орж ирлээ.

Завь бүрээс өөр лүү нь ирэх төмөр зэвсгүүдийг үл тоон, жадны ард бэхэлсэн олснуудыг хооронд нь орооцолдуулж байлаа. Өөрөө хэдийгээр жад, олон янзын уяа оосрт ороолдсон авч Моби Дик Ахабын завины нум руу хурдлав. Одоо тэр хөгшин ахмадад хийх ганцхан зүйл байсан нь өөрийгөө хэрж буй олсыг тасдах байв. Гэвч тэр үүнийгээ хийхэд ихээхэн бэрхшээл учирч байсан нь Моби Дик орооцолдсон олс руу гэнэ гэнэ довтлон, түүнийг барьц алдуулж байсан юм.

Цагаан халим мөн Стабб, Пласк нарын завийг өөр лүүгээ татан, хооронд нь мөргөлдүүлж, тэр хоёрыг яг л далайд байгаа хоёр бяцхан хясааг том давалгаа хуйлран авч одох шиг хөмрүүлж орхилоо. Тэгээд халим далайн гүн рүү шумбан, буцалж буй эргүүлэг рүү орон алга болжээ. Хоёр завь усан дээр зүг чиггүй эргэлдэхэд Пласк халимын аймшигт эрүүнээс болгоомжлон хөлөө дэмий л сарвалзуулна.

Стабб дээшээ гарах гэж тусламж эрэн хашгирлаа. Ахаб аюулд өртсөн завинуудаа аврахаар эргүүлгийн зүг явж байтал гэнэт завьтайгаа хамт далайгаас дээш буудагдсан юм шиг шидэгдэв. Тэр яг л нүдэнд үл үзэгдэх уяагаар татуулсан юм шиг дээшээ дүүлж байсан авай. Моби Дик өргөн духаараа Ахабын завины доороос мөргөж, түүнийг агаарт ийнхүү дахин дахин эргэлдүүлсэн юм байж. Эцэст нь сая нэг юм завь усан дээр буув, гэхдээ хөмрөгдөн буусан юм. Ахаб болон түүний эрчүүд түүн дороос гарах гэж чамгүй хичээн тэмцэлдэж билээ. Удалгүй халим хийсэн ажилдаа санаа амрав бололтой, духаараа далайн усыг яран одоход орооцолдон мушгирсан олснууд түүний араас чирэгдэв.

Яг л түрүүчийнх шигээ Пекуд усан дээр байгаа багийнхнаа аврахаар ирж, эрчүүдээ суулган, сэлүүр, жад зэргийг нь хамж авах завь явуулжээ.

Ахабыг авахад тэр өөрийнхөө завины хугархай хагасаас зүүгдэн байлаа. Тэнд байгаа эрчүүдээс үхлийн шарх авсан хүн байсангүй, зөвхөн мөр, бугуй, шагайгаа булгалах зэргээр л бэртжээ.

Пекутын тавцан дээр Ахаб Старбакийн мөрийг түшин зогсож байлаа. Ахмадын ясан хөл хугарчээ. Түүний ясан хөлөөс үзүүртэй жаахан хэсэг л үлдсэн байв.

- Хөгшин Ахаб гэмтээгүй ээ, хугарсан яс ч алга. Алив наад жадаа надад таяг болгон агуулаач. Тэгээд эрчүүдээ нааш нь дууд! гэж Ахаб хашгиран хэлэв.

Багийнхан бүгдээрээ нэг дор цуглахад ахмад нэг хүний царайг л хайж байлаа. Тэр бол


Педалла, гэвч тэр энд байсангүй.

- Тийм ээ, эрхэм ээ, тэр таны олсны орооцолдоон дунд баглагдчихсан байсан. Би тэрнийг доошоо халимд чирэгдэн орсон байх гэж бодож байна гэж Стабб хэлэв.

- Миний олс оо? Миний олсонд оо? Чирэгдсэн гэв үү? Тэгэхээр миний үхлийн зөн биелж байгаа нь энэ юм биз дээ?, - хэмээн Ахаб дуу алдав. - Хурдан жадаа цуглуулаарай. Хэрэв би энэ дэлхийг арвантаа тойрох, эсвэл шууд голоор нь гатлах байсан ч гэсэн би Моби Дикийг барина.

- Ээ, бурхан минь! Та хэзээ ч түүнийг барьж чадахгүй. Хөгшин минь, үүнийг ойлго. Одоо ингэхээ больё. Энэ чинь галзуурал. Бид бүтэн хоёр өдрийн турш түүний араас явлаа шүү дээ. Энэ хоёр өдөр завинууд маань хэмхэрч, өөрсдөө ч гэмтлээ. Таны хөл чинь хүртэл алга боллоо. Энэ чинь хангалттай сэрэмжлүүлэг биш гэж үү. Та биднийг бүгдийг нь далайн ёроолд булшлах хүртлээ тэр аймшигт загасаа хөөх гэж үү? хэмээн Старбак хашгирав.

- Энд тэртээ сая жилийн өмнөөс л далай давлагаалан хуйлрах хууль байсаар ирсэн шүү дээ, эрчүүл минь. Инээцгээ, тайвширцгаа, тэр бидэнд живж яваа зүйл гадарга дээр хоёронтаа гарч ирдгийг үзүүллээ. Дараа нь тэр... үүрд мөнх живэхийн тулд дахин гарч ирдэг. Моби Дик ч мөн хоёр өдрийн турш хөвж чадсан. Гэхдээ тэр маргааш сүүлчийн удаа усаа оргилуулахаар гарч ирнэ.



Ингэж хэлсэн ч Ахаб “Педалла өөрийгөө надаас түрүүлж үхнэ гэж зөгнөсөн. Гэвч тэр намайг үхэхээс өмнө дахин нэг удаа надад харагдана гэж хэлсэн шүү дээ! Одоо надад тархийг минь гашилгаж байх оньсого бий боллоо. Би үүний хариуг ямар ч байсан олно” хэмээн өөрөө өөртэйгээ ярьсаар байв.

## Арван долдугаар бүлэг.

### Ер бусын зөн биеллээ оллоо

Гурав дахь өдрийн үүр цайлаа. Шөнийн турш харуул хийж хоносон тэр хүн багийн бусад гишүүд харуус харахаар шураг дээр гарч ирэхэд сэтгэл нь сая амарчээ. Алдсан ясан хөлийнхөө оронд модон хөл хийж авсан Ахаб өнөө л олсон сагсандаа суун дээшээ гарсан байлаа. Цаг орчмын дараахан далайн мандлыг харуулдаж явсан далайчид маань оргилуурыг олж харав. Тэгээд гурван удаа “Тэр тэнд байна!” гэх дуу гол шураг дээрээс сонсогдлоо.

- За ингээд бид гурав дахь удаагаа нүүр нүүрээрээ учрах шив, Моби дик? гэж Ахаб хэлэв.

Тэгснээ шургийн толгойг зөөлөн илбээд,

- Баяртай, шураг минь, би доошоо буулаа. Намайг явсны дараа тэр халимыг гярхай харж байгаарай. Бид маргааш дахин ярилцах болно, харин өнөө орой биш шүү. Цагаан халим энүүхэн доор толгой, сүүлнээсээ уяулчихсан хэвтэж байхыг харангаа ярилцамз! гэжээ.

Ахаб доошилж байтал өнөөх оньсого шиг бодол нь түүний толгойд ахин орж ирлээ. Тэрээр өөрөө өөртөө ийн шивнэнэ: Гэвч Педалла юу гэж хэллээ? Тэр миний өмнө үхнэ. Тэгээд намайг дахин нэг удаа харна гэсэн. Гэвч хаана? Би түүний живсэн газраас их хол байна шүү дээ. Үгүй ээ, Педалла, чи өөрийнхөө үхлийг зөв зөнгөсөн авч Ахабын талаар алдаж боджээ!





Ахаб завинд суухад бэлэн болсны дараа Старбак руу эргэн,

- Надтай гар бариач, эрхэм ээ. Би хөгшин, үнэхээр хөгшин хүн! гэж хэлэв.

Нүдэнд нь нулимс цэлэлзсэн Старбак,

- Өө, ахмад минь, бүү яваач! Зоригт үнэнч дайчин тань танаас уйлан гуйж байна гэхэд,

- Доош нь буулга! гэж Ахаб хэлээд түүнээс гараа татан авлаа.

Завинууд доошилж байхад гол шурагнаас дохио ирсэн хэдий ч Ахаб үл хайхран доош буужээ. Ахабын завийг хуйларсан давлагаа цохиход,

- Цохиод бай! Цохиод бай! Би айхгүй, Моби Дикийг гарч ирэхэд би хүлээж байх болно! Өө, Педалла чиний буруу байжээ, энд надад авс болон шарил ачих тэрэгний аль, аль нь байхгүй. Санаж яваарай, намайг зөвхөн олс л үхэлд хүргэж чадна, ха ха ха! хэмээнэ.

Гэнэт далайн ус хуйлран эргэлдэж давлагаа нь томрон томорсоор аварга том цагираг мэт болоход багаахан хэмжээний нижигнэх дуун сонсогдлоо. Хүн бүр л жад сэрээ олсоо атган амьсгаа дарав. Эцэст нь халим далайгаас цухуйлаа. Урьд өдрийн шинэ шархандаа галзууртлаа хилэгнэсэн Моби Дик шууд урагшаа дайрав. Сүүлээ завь хоорондуур шидлэн, олсыг нь тасдаж, жадыг нь хугачиж байлаа. Халим тэдэн рүү эргэн довтлоход нэгэн хашгирах чимээ дуулдав. Халимын олс жад дүүрсэн нуруун дээр Педаллагийн хагас зэрэмдэг цогцос харагдах нь тэр. Түүний хараатай нүд хөгшин Ахаб руу чиглэсэн байв. Ахмадын гараас жад сугаран унахад тэрээр уртаар амьсгаа авч,

- Тэгэхээр чи үнэн хэлжээ Педалла? Одоо би чамайг үхсэний чинь дараа дахин харж байна. Хүүр ачдаг тэрэгний тухайд... энэ бүгд үнэн байж! Тэгэлгүй яахав. Тэр хүүрийн тэрэг нь хүний гараар хийгдээгүй Моби Дик. Гэхдээ хоёр дахь тэрэг хаана байна аа? гэж Ахаб шивнэснээ сандран бужигнаж буй багийнхан руугаа эргэн харлаа.

- Доошоо болцгоо, эрчүүд ээ! Миний байгаа энэ завинаас түрүүлж үсрэх гэж оролдсоныг нь би жадалж орхино шүү. Та нар жирийн эрчүүд биш та нар миний гар, миний хөл, тиймээс та бүхэн надад захирагдах ёстой. Халим одоо хаана байна? хэмээн хашгирав. Моби Дик тэндээс маш хурдан сэлэн одоход далайд мөр нь зурайн үлдэв.

Ахаб түүнийг нэхэн эргэлээ. Тэрээр Пекутынхаа хажуугаар өнгөрөхөд Старбак тавцан дээрээс түүнийг дуудан,

- Хөөе, Ахаб буцахад оройтоогүй байна, хараач! Моби Дик таныг нэхээгүй. Та л түүний араас нэхэж байна шүү дээ! гэсэн ч Ахаб сэлүүрчдэдээ халимын үргэлжлүүлэх мөрдөхийг тушаав.

Тэрээр онгоц руугаа хяламхийн харахад Таштего, Кюкег, Даггоо нар их л хүлээсэн янзтай шураг өөд авирцгааж байгаа нь харагдана. Мөн Пекутын ойролцоо сэлүүрчид эвдэрсэн хоёр завьтайгаа ноцолдож байгааг ч олж харлаа. Онгоцныхоо цонхон тушаа өнгөрөхдөө Стабб, Пласк нар боодолтой шинэ жаднууд дунд их завгүй байгааг харав.

Ахабын сэлүүрчдэд хүндрэл учрав. Аварга махчин загаснууд завиных нь эргэн тойронд гарч ирэн, боломж олдох бүрийд сэлүүрийнх нь үзүүрээс зулгаана.

- Тэдэнд битгий анхаарлаа хандуул, тэдний шүдийг зүгээр л сэлүүрийн хоног гэж мэд! Тэгж л байг! хэмээн Ахаб хашгирна.

- Гэхдээ эрхэм ээ, хазах бүрт сэлүүр илүү жижигхэн болж байна шүү дээ!

- Зүгээр ээ, сэлүүр тэсэхдээ л тэснэ. Наадуул чинь хөгшин Ахаб, Моби Дик хоёрын алиныг нь сэгийг идэх гэж хүлээж байгаа бол?

Тэд цагаан халимын хажууханд ирэхэд халим оргилуураасаа тэднийг бүхэлд нь бүрхэхүйц их цагаан манан гаргалаа. Ахаб хоёр гараа толгой дээрээ өргөн өнөөх хараал идсэн халим руугаа жадаа зоож, довтлов. Цагаан халим өвдсөн бололтой түүний бяцхан завь руу эргэн довтолж, хазайлгаад ирлээ. Гурван сэлүүрчин нь далайд шидэгдсэн авч Ахаб завьтайгаа зууралдан, үлдэж амжив. Халим далайн гүн рүү шунгахад Ахаб эрчүүд рүүгээ,

- Шалавхан уяанаас бариарай! хэмээн хашгирна.

Гэвч олснууд яахин тэр их хүчийн тэсэх вэ, хоосон агаарт тасран үлдэв.

Моби Дик эргэн гарч ирэхдээ Пекутын их биеийг нь олж харсан байжээ. Магадгүй эдгээр явдлын бүхий л шалтгаан болсон түүнийг дайрахад бэлэн болоод тийшээ зүглэлээ. “Халим! Онгоц!” гэж сэлүүрчид хашгиралдана.

- Онгоц... онгоц... Хазай... хазай... Далай минь, Ахабт дайснаа дахин нэг дайрах боломж олгооч дээ. Эрчүүдээ хурдлаарай, та бүхэн онгоцоо аврахгүй юм гэж үү? хэмээн Ахаб зэрлэг хүн шиг хашгирав.

Пекутын тавцан дээр байсан эрчүүд өөрсдийг нь эгц чиглэн дайрч буй тэр халимыг цоо ширтэн, зарим нь хашгиралдаж, зарим нь залбирцгаана.

- Хөөе, Ахаб, чи юу хийснээ хараач, тэр биднийг чиглээд ирлээ! Бурхан минь, яг одоо хажууд минь байгаач! Тэр баярлаж хөөрсөн халим биднийг бүгдийг нь залгих гэж байна! хэмээн Старбак хашгирав.

Өс хонзондоо шатсан Моби Дикийн хүчирхэг цагаан толгой онгоцны баруун талыг бут мөргөв. Эрчүүд гэнэтийн доргилтоос болж, уулын оргилоос ус сад тавин асгарах мэт нүүрээрээ харуулдан унацгаав.

- Хоёр дахь хүүр зөөгч, энэ чинь онгоц өөрөө байна шүү дээ! Энэ чинь америк мод. Тэгэлгүй яахав, эд бүгд Педаллагийн өнөөх америк модон авсны тухай яриа байна гэж Ахаб завинаасаа дээш өлийн хашгирлаа.

Живж буй онгоцны хэвлий доогуур халим шунган гарч, Ахабын завины хажуугаас хэдхэн ярдын зайтай гарч ирлээ. Тэгснээ хэсэг хугацааны турш огт хөдөлгөөнгүй болов.

- Нартаас явах миний ээлж ирлээ! Өө, Пекут! Миний гайхамшигт үхлийн онгоц чи надгүйгээр живж, надгүйгээр мөхөх ёстой юм гэж үү? Ахмадын чинь хамаг найдвар, бахархал ингээд дууслаа. Ийм ганцаардмал, гашуун амьдралын дараа үхэл минь яаж ганцаардаж, гашуудах бол оо? Чи бүгдийг устгасан боловч юуг ч эзэлж чадаагүй, муу халим минь. Би чамайг үзэн ядаж байгаа болохоор эцсээ хүртэл тулалдана! Сүүлчийн амьсгалаа хүртэл чам руу би хорт зэвсэг болгон илгээнэ! Би чамайг хөөж явах зуур намайг тасар татан хаяарай! Хараал хүртсэн халим, май миний жадыг ав!

Ахаб хамаг хүчээрээ жадаа шидлээ. Халим хүчтэй жаданд оногдоод тун хурдан хөдлөхөд жадны олс орооцолдож эхлэв. Ахаб түүнийг орооцолдуулахгүйг хичээн бөхийсөн авч олс түүний хоолойгоор ороогдох тэр агшинд тэрээр завинаасаа нисэх мэт унав.

Багийн гишүүд юу болоод буйг ухаарч ч амжаагүй байхад тэр ийн алга болжээ... Олс түүнийг нөгөө ертөнц рүү замчлан одов оо.

Нэгэн хормын турш багийн гишүүд ховдуулсан мэт таг чимээгүй зогсож, ам амандаа дэмий л,

- Хөлөг онгоц хаачив аа? Ээ, Бурхан минь, Пекут хаачив аа? хэмээцгээнэ.



Манан дунд Пекут далайн гүн рүү улам бүр шингэн алга болох агшинд хамгийн өндөр шураг дээрх үнэнч харуулын жадчид хэрэгтэй байран дээрээ хөдөлгөөнгүй зогссоор л. Дараа нь усны эргүүлэг сүүлчийн ганц завийг маань хаман авахдаа багийн бүх гишүүд, сэлүүр, жад, ер нь л Пекутын гэх бүх зүйлийг эргүүлдэн байснаа далайн ёроол руу үүрд аван одлоо. Цагаан

халим мөрөө хөөн алсарч, харин эх далай таван мянган жилийн турш хүчирхэг амирлангуй  
давлагаалж ирсэн шигээ зөөлөн бидэртэнэ...

## Арван наймдугаар бүлэг

### Ганцаараа амьд үлдэв

Түүх маань ийнхүү төгсөж, би тэрхүү сүйрлээс ганцаараа амьд үлдсэн юм.

Харлан хөөсрөх тэр эргүүлгэн дунд би яахаа мэдэхгүй байтал авс шиг хэлбэртэй аврах завь давлагаан дундаас хөвөн гарч ирлээ. Хэдий өөрөө үхсэн ч хамгийн сайн анд маань миний амийг аварсан хэрэг. Энэ бол Кюкегийн өнөөх авсан завь байсан юм.



Би бүтэн өдөр, бүтэн шөнө хөвсөн. Махчин загаснууд миний хажуугаар сэлэн өнгөрөхдөө надад ямар ч хор хүргэсэнгүй, бас далайн шонхрууд толгой дээгүүр минь өнгөрөхдөө хошуугаа хамхин өнгөрцгөөж байв. Би задгай далайд тийнхүү хөвж явахдаа их л юм бодсон сон. Ахабыг өөрийг нь үхэлд аваачсан тэр зүйлийн тухай, бас цагаан халим яаж догшин хариулт өгсөн тухай бодсон. Тийн хөвөн явахдаа миний өчүүхэн амь, бие, сэтгэлийг минь аварсан Кюкегийн сайхан сэтгэлийн тухай дурсахгүй байж чадсангүй.

Хоёр дахь өдөр нэгэн онгоцны далбаа алсаас ойртож байгааг би олж харлаа. Тэд намайг аварсан юм. Тэр бол алга болсон хүүхдүүдээ өдийг хүртэл эрсээр байгаа Речил байв. Гэвч тэр зөвхөн Измайл намайг, өөр нэгэн өнчин амьтныг аварсан нь энэ байлаа.

